

Агуулга

	Товчилсон үгсийн жагсаалт	2
	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	3
<u>Тайланг бэлтгэсэн:</u>	<i>Бүлэг 1. Ойн арга хэмжээг оновчтой төлөвлөөгүй байна</i>	
ҮАГ-ын нэгдүгээр газар		
<i>Захирал</i> <i>Д.Ганбилэг</i>	<ul style="list-style-type: none">• Төлөвлөгөөнд тусгагдсан зарим ажил ойн арга хэмжээний үндсэн зорилготой тэр бүр уялдаагүй байна	5
<i>Аудитын менежер</i> <i>Ж.Батсайхан</i>	<ul style="list-style-type: none">• Төсвийг үндэслэлтэй тооцох шаардлагатай байжээ	5
<i>Шинжээч</i> <i>Ц.Цолмон</i> <i>Б.Болормаа</i>	<ul style="list-style-type: none">• Зарим арга хэмжээ товлосон хугацаандаа дуусаагүй байна	6
	<i>Бүлэг 2.Төсвийн хөрөнгөд үрэлгэн ханджээ</i>	
2007 оны 12 дугаар сар	<ul style="list-style-type: none">• Үндэсний хороо хөрөнгийн зарцуулалтад сайтар хяналт тавиагүй байна	7
	<ul style="list-style-type: none">• Хэрэгжүүлэгч байгууллагууд төсвийн хөрөнгөөс өөрсдийгөө шагнажээ	9
<i>Уг тайланг дараахь хаягаар ҮАГ-ын вэб сайт-аас үзнэ үү:</i>	<ul style="list-style-type: none">• Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулжээ	9
<u>www.mnao.pmis.gov.mn</u>	<i>Бүлэг 3. Сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах шийдвэрийг Удирдах зөвлөл гаргажээ</i>	
<i>Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261885 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.</i>	<ul style="list-style-type: none">• “Их Монгол-800” сан хуулийн дагуу байгуулагдаагүй байна	14
<i>ХАЯГ: Үндэсний аудитын газар Засгийн газрын 4 дүгээр байр, Бага тойруу-6, Улаанбаатар-46 Монгол Улс</i>	<ul style="list-style-type: none">• Сангийн хөрөнгийн дийлэнх хувь төсвийн хөрөнгөөс бүрджээ	15
	<ul style="list-style-type: none">• Сангийн хөрөнгийг зориулалт бус зүйлд зарцуулжээ	16
	<ul style="list-style-type: none">• Хөрөнгийн зарцуулалтад хяналт тавиагүй байна	17
	<i>Дүгнэлт</i>	19
	<i>Холбогдох байгууллагын санал</i>	20
	<i>Зөвлөмж</i>	40

Товчилсон үг

УИХ	Улсын Их Хурал
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ТЗҮААЭГ	Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газар
ГХЯ	Гадаад хэргийн яам
ТТХГ	Төрийн тусгай хамгаалалтын газар
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
БХЯ	Батлан хамгаалах яам
ЗТАЖЯ	Зам тээвэр, аялал жуулчлалын яам
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
МУИС	Монгол Улсын Их Сургууль
ШУА	Шинжлэх ухааны академи
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
МУГЖ	Монгол Улсын гавьяат жүжигчин
ТББ	Төрийн бус байгууллага
ОХУ	Оросын холбооны улс
ӨМӨЗО	Өвөр монголын өөртөө засах орон
ҮХЯ	Үйлдвэр, худалдааны яам
АМГТХЭГ	Ашигт малтмал, газрын тосны Хэрэг эрхлэх газар
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ТҮК	Тохижилт үйлчилгээний компани
ҮДБЭЧ	Үндэсний дуу бүжгийн эрдмийн чуулга
НББ	Нягтлан бодох бүртгэл
ДБЭТ	Дуурь бүжгийн эрдмийн театр
ЦДБЭЧ	Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулга
ХБК	Хөгжим бүжгийн коллеж
УФ	Улсын филармони
УДЭТ	Улсын драмын эрдмийн театр

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны санал, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2007 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Энэхүү аудитын зорилт нь Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойг зохион байгуулах Үндэсний хороо төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу, үр ашигтай зарцуулсан эсэхийг дараахь чиглэлээр шалгаж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд чиглэгдлээ. Үүнд:

- Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн арга хэмжээний хүрээнд зохион байгуулах ажил, арга хэмжээний төлөвлөлт
- Ойн арга хэмжээний төсвийн зарцуулалт
- “Их Монгол-800” сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, тайлагнал

Аудитыг Үндэсний хорооны ажлын алба, Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газар болон төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч зарим аж ахуйн нэгжийг хамруулан хийлээ.

Аудитыг гүйцэтгэхдээ холбогдох хүмүүстэй ярилцлага хийх, ажлын гүйцэтгэлийг баримт материалтай тулган баталгаажуулах, ажиглалт, дүн шинжилгээ хийх зэрэг гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглав.

Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэглэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Бүлэг 1

Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн
ойг зохион байгуулах Үндэсний хорооны
төсвийн хөрөнгийн зарцуулалт

Ойн арга хэмжээг оновчтой
төлөвлөөгүй байна



1.1. Монгол Улсын Ерөнхийлөгч 2001 оны 5 дугаар сарын 11-нд Чингис хааны мэндэлсний 840 жилийн ойг 2002 онд, Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойг 2006 онд улс орон даяар төр ёсны их баяр болгон тэмдэглэх тухай 118 дугаар Зарлиг буулгаж, тусгай хөтөлбөр боловсруулахыг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгон уг хөтөлбөрийн агуулгад дараахь зүйлсийг багтаан оруулахыг даалгажээ. Үүнд:

- ✓ Чингис хааны дурсгалын болон онгон шүтээний ёслол хүндэтгэлийн цогцолбор барьж байгуулах,
- ✓ Их Монгол Улсын түүх болон Чингис судлалыг идэвхжүүлэх, олон улсын эрдэм шинжилгээний хурал, семинар, судалгаа шинжилгээний аялал, экспедици зохион байгуулах,
- ✓ Музейн үзвэр, фондыг сэргээн баяжуулах, өргөтгөх, дотоод, гадаадад үзэсгэлэн гаргах,
- ✓ Их Монгол Улс, Чингис хааны тухай кино бүтээх, урлаг уран сайхны бусад олон төрлийн бүтээл туурвих санаачилгыг дэмжих,
- ✓ Дэлхийн монголчуудын түүх соёл, урлаг, спорт, бизнес ажил хэргийн холбоо харилцааг өргөжүүлэх,
- ✓ Чингис хааны одон буй болгох, нэрэмжит болгох зэрэг арга хэмжээг багтаан оруулах.

1.2. Зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газар түүхт ойд бэлтгэх, тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг удирдан зохион байгуулах Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 2001 оны 112, 2005 оны 120 дугаар тогтоолоор тус тус баталжээ.

1.3. Монгол Улсын Ерөнхий сайдаар ахлуулсан Засгийн газрын гишүүд, зарим аймаг, нийслэлийн Засаг дарга нар, дэд сайд зэрэг 19 хүний бүрэлдэхүүнтэй Үндэсний хороог бүтээн байгуулалт, мэдээлэл сурталчилгаа, түүх уламжлал, соёлыг түгээн дэлгэрүүлэх, урлаг уран бүтээл, баяр наадам, зочин хүндэтгэл, аялал жуулчлал, төсөв санхүүгийн гэсэн 7 ажлын хэсэгтэй байхаар зохион байгуулжээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан зарим ажил ойн арга хэмжээний үндсэн зорилготой тэр бүр уялдаагүй байна

1.4. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар чиглэл болгосны дагуу Үндэсний хороо ард иргэд, аймаг, нийслэл, албан байгууллага хамт олны санал санаачилгыг нэгтгэн 100 гаруй арга хэмжээг багтаасан түүхт ойг тэмдэглэх, зохион байгуулах арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөг бүтээн байгуулалт, мэдээлэл сурталчилгаа, түүх, уламжлал соёлыг түгээн дэлгэрүүлэх, урлаг уран бүтээл, цэнгүүн, баяр наадам, зочин хүндэтгэл, аялал жуулчлал, гадаад сурталчилгааны ажлын хэсгүүдээр авч үзэн хорооны хуралдаанаар хэлэлцүүлж Үндэсний хорооны 2005 оны 7 дугаар сарын 15-ны 05/07 дугаар тогтоолоор баталсан байна.

1.5. Дээрх төлөвлөгөөнд Үндэсний хорооны 2006 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 3 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулан 93 ажил, үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ч 2006 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 9 дүгээр тогтоолоор дахин өөрчлөлт оруулж 97 ажил зохион байгуулахаар шинэчлэн баталжээ.

1.6. Баталсан төлөвлөгөөнд тусгагдсан дараахь арга хэмжээнүүд ойн арга хэмжээний үндсэн агуулга чиглэлтэй тэр бүр уялдаагүй байна.



1.7. 80 тохой Майдар бурхны хатгамалд 80,0 сая төгрөг зарцуулсан бөгөөд түүнийг сүм хийд, сүсэгтнүүд хийх боломжтой байсан. Энэ хөрөг хэдийгээр урлагийн бүтээл боловч түүнийг зохих ёсоор хадгалах, олон нийтэд дэлгэн харуулах барилга алга байна.

1.8. Дундговь аймгийн Гурван сайхан сумын нутаг дахь "Их Газрын чулуу" хэмээх газар зуны задгай театр, зууны манлай уртын дуучин Н.Норовбанзадын дурсгалд зориулсан хөшөөнд 70 сая төгрөг зарцуулсан.



Төсвийг үндэслэлтэй тооцох шаардлагатай байжээ

1.9. Үндэсний хороо ойн арга хэмжээг төлөвлөхдөө мэргэжлийн байгууллага, иргэд болон эрдэмтдийн санал бодолд үндэслэсэн гэх боловч хичнээн төгрөгийн зардал гарахыг төлөвлөснөөс бус түүнийг хэрхэн үр ашигтай зарцуулах, олох орлогын

хэмжээ зэргийг тооцоогүй, зөвхөн нэг удаа болоод өнгөрнө гэсэн сэтгэлгээгээр хандсан байна.

1.10. Зарим арга хэмжээ тодорхой хэмжээний орлого олж, өөрийгөө санхүүжүүлж болохоор байжээ. Тухайлбал,

- ✓ Соёл, яруу найргийн академийн зохион байгуулсан “Дэлхийн яруу найрагчдын 26 дугаар их хурал”-д гадаадын 300 гаруй зохиолч, яруу найрагчид оролцож, гадаадын нэг төлөөлөгч 400.0 ам.доллар, дотоодын яруу найрагч 70.000 төгрөгийн хураамж төлсөн байна.
- ✓ Олон улсын Монгол судлалын холбооноос зохион байгуулсан “Олон улсын Монголч эрдэмтдийн 9 дүгээр их хурал”-д гадаадын 280, дотоодын 126 төлөөлөгч оролцож, гадаадын эрдэмтдээс 23,5 мянган ам.доллар, дотоодын төлөөлөгчдөөс 5,1 сая төгрөгийн орлого олжээ.

Зарим арга хэмжээ төвлөсөн хугацаандаа дуусаагүй байна

1.11. Үндэсний хорооны нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дагуу тодорхой хугацаанд хэрэгжүүлэх ёстой байсан зарим ажил, үйлчилгээ хугацаандаа хэрэгжээгүй байна. Тухайлбал:

№	Үйл ажиллагааны нэр, зориулалт	Гүйцэтгэгчийн		Зарцуулсан мөнгөний дүн /сая төгрөгөөр/	Зарцуулалтын тайлан гаргаж өгсөн эсэх
		Нэр	харьяалах байгууллага		
1	Төрийн 9 бэлэгдэл	Роза	Урчуудын эвлэлийн хорооны уран бүтээлч	69,9	үгүй
2	Их хаадын ургийн бичгийг цахим хэлбэрийн ном болгон хийх	Намсрай	Молон трейд ХХК	2,0	үгүй
3	Цахим үзмэрүүдийн бүрдүүлэлт	Д.Ганчимэг	Чимэг-Эрдэнэ ХХК	29,4	тийм
4	Монгол хэл бичгийн үзмэрүүд	Д.Төмөртогоо	МУИС-ийн Монгол судлалын төв	17,3	тийм
5	Монгол цэргийн зэр зэвсгийн үзмэр	Шагдар	ШУА-ийн Түүхийн хүрээлэн	43,0	үгүй
6	Газрын зурагнууд		Түүхчдийн холбоо	12,5	үгүй
7	Орхоны хөндийн соёлын дурсгалт нутаг		Хар хорин дээд сургууль	1,9	үгүй
8	Монгол төрийн түүхийн бодит цомог (НТӨ III зуунаас НТ-ын 2006 он хүртэлх үеийг хамруулах)	Т.Чимэд	Шастир танхим/ төрийн түүхийн музейн гэрээт ажилтнаар давхар ажилладаг/	29,0	үгүй
9	Миний түүх, миний соёл танин мэдэхүйн нэвтрүүлэг	Ц.Ариунаа	Монголын урлагийн зөвлөл	70,0	тийм
	Нийт дүн			275,2	

1.12. Эдгээр гүйцэтгэгч байгууллагуудын дийлэнх нь Төрийн түүхийн музейн үзмэрийг цахим болон биет хэлбэрээр бүрдүүлж 2006 оны 7 дугаар сард нийлүүлэх гэрээтэй ч өнөөдрийг хүртэл бүрэн гүйцэтгээгүй байна.

Бүлэг 2

Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн
зохион байгуулах өнгөрүүлэх Үндэсний
хорооны төсвийн хөрөнгийн зарцуулалт

Төсвийн хөрөнгөд үрэлгэн ханджээ



2.1. Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн хүрээнд хийж гүйцэтгэх, зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг Үндэсний хорооны 2005 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн 05/02 дугаар тогтоолоор 15,3 тэрбум төгрөгт багтаан хэрэгжүүлэхээр баталжээ.

2.2. Засгийн газар шинээр байгуулагдсаны дараа Үндэсний хороо дахин хуралдаж 2006 оны 6 дугаар сард 9 дүгээр тогтоолоор төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж 97 арга хэмжээнд 17,8 тэрбум төгрөг зарцуулахаар эцэслэн баталжээ. Гэхдээ энэ хөрөнгөөс 2.4 тэрбум төгрөг нь 2005 онд зарцуулагдсан, 14,9 тэрбум төгрөгийг 2006 онд зарцуулахаар төлөвлөжээ.

2.3. УИХ 2006 оны 6 дугаар сард төсвийн тодотголыг авч хэлэлцээд ойг тэмдэглэх нэгдсэн арга хэмжээнд 2006 онд шаардагдах хөрөнгийн 9.3 тэрбум төгрөгийг ТЗҮААЭГ-ын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд, 5.7 тэрбум төгрөгийг ЗГХЭГ-ын даргын төсвийн багцын урсгал зардалд оруулж баталжээ.

Үндэсний хороо хөрөнгийн зарцуулалтад сайтар хяналт тавиагүй байна

2.4. Үндэсний хороо дүрмийнхээ дагуу ойн арга хэмжээг төлөвлөх, батлах, гүйцэтгэгчийг томилон ажиллуулах, холбогдох байгууллагаар шийдвэр гаргуулах, арга хэмжээний хүрээнд зарцуулагдах хөрөнгө, санхүүгийн нөөцийг бүрдүүлэх, хуваарилсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, хөтөлбөр төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, батлагдсан төсвийн зарцуулалтын тайланг хагас бүтэн жилээр дүгнэж хуралдаанаараа хэлэлцэн Засгийн газарт тайлагнах ёстой.

2.5. Энэ чиг үүргийг Үндэсний хорооны ажлын албаны нарийн бичгийн дарга нар хариуцан гүйцэтгэх ёстой атал ажлын хавсарга мэт үзэн хайнга хандсан бөгөөд Үндэсний хороо ч энэ талаар тодорхой арга хэмжээ аваагүй байна.

2.6. Үндэсний хороо Урлаг уран бүтээлийн хэсгийн “Өүлэн эх” дуурийг 2005 оны 12 дугаар сард 25,0 сая төгрөгөөр санхүүжүүлж, уг бүтээл 2006 оны 2 дугаар сард олны хүртээл болж жуулчны улиралд тавигдахаар Үндэсний хорооны ажлын албатай гэрээ байгуулсан ч хугацаандаа багталгүй 2006 оны 12 дугаар сард тавигдсан байна. Хугацаа хоцорсон шалтгааныг зохиолч нь хөгжмөө бичиж чадахгүй байсан гэж тайлбарлаж байгаа ч шагналаа 2006 ондоо бүрэн авсан байна. Гэтэл дахин Их Монгол-800 сангаас хөгжмийн зохиолчийн ажлын хөлсөнд 5,8 сая төгрөгийг нэмж олгожээ. Хугацаандаа гэрээний үүргээ биелүүлээгүй байхад ямар нэгэн хариуцлага тооцоогүйн дээр нэмэлт санхүүжилт олгосон байна.



2.7. Үндэсний хороо Баяр наадам, зочин хүндэтгэлийн хэсгийн гадаадын зочин төлөөлөгчдийн бэлэг дурсгалд зориулж Монголын нууц товчоог англи хэлээр хэвлүүлэн 300 ширхгийг ТЗҮААЭГ-ын бэлгийн фондод наадмын өмнө МУИС-ийн хэсэг багш нараас хүлээн авахаар 8,5 сая төгрөгийн гэрээ хийсэн боловч (бэлгийн чанарт

таарахгүй гэж төрийн ёслолын алба үзсэн шалтгаанаар) 184 ширхгийг 12 дугаар сард хүлээн авч үлдэгдлийг аваагүй байна.

2.8. Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэнгээс “Монголчуудын түүх соёлын атлас” хэмээх Монголын эрдэмтдийн бүтээлийг англи хэл дээр орчуулан хэвлүүлж 300 ширхгийг 2006 оны 7 дугаар сарын 1-нд хүлээн авч бэлэг дурсгалд зориулахаар 10,0 сая төгрөгийн гэрээ хийсэн боловч уг номоос 2006 оны 12 дугаар сард 48 ширхгийг, 2007 оны 1 сард үлдэгдлийг хүлээн авчээ. Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэн уг номыг “Интерпресс” ХХК-иар хэвлүүлэхээр гэрээ хийсэн боловч 800 ширхгийг БНХАУ-д хэвлүүлсэн байна.

2.9. Бүтээн байгуулалтын ажлын хэсгээс 35 мм хальснаас аливаа дүрсийг DVD, VCD, видео болон фото зурганд буулгадаг “Prolok-Arri” аппаратурыг тендер зарлан ХБНГУ-аас худалдан авахаар “Шастир танхим” ББН-тэй гэрээ байгуулан 86,0 сая төгрөгийг олгож гаалийн татварт 10,2 сая, томилолтын зардалд 7,4 сая төгрөг, нийт 17,5 сая төгрөгийг Үндэсний хорооны ажлын албаны төсвөөс зарцуулжээ. Гэтэл уг аппаратыг авчирснаас хойш Үндэсний архивын газарт хэдэн сарын дараа хүлээлгэн өгсөн ч комисс чанарын шаардлага хангахгүй учир уг хөрөнгийг хүлээн авах боломжгүй гэж дүгнэжээ.

2.10. Бүтээн байгуулалтын ажлын хэсэг Төрийн түүхийн музейн аппаратур, цахим үзүүлбэрийг худалдан авах хязгаарлагдмал тендер зарлаж, ТЗҮААЭГ “Оргилсофт” ХХК-тай 219,4 сая төгрөгийн гэрээ хийж зарим тоног төхөөрөмжийг хүлээн авсан байна. Гэтэл тендер зарласан тоног төхөөрөмжийн гэрээнд заагдсан марк, хэмжээ нь тохирохгүй байна. Тухайлбал том дэлгэцийн хэмжээ 5x2м хэмжээтэй байхад одоо нийлүүлэх дэлгэц 3x2 м, үзмэрээ нийтэд дэлгэн үзүүлэхэд 19 инчийн 20 дэлгэц шаардлагатай гэж тендер зарласан боловч 17 инчийн дэлгэц нийлүүлэхээр гэрээ хийн хүлээн авчээ. Аудитын тайлангийн төсөлд өгсөн тайлбарт гэрээгээ дахин дүгнэж зөрүүг нь тооцон нэмэлт тоног төхөөрөмж авахаар тохиролцсон гэж дурджээ.

Хэрэгжүүлэгч байгууллагууд төсвийн хөрөнгөөс өөрсдийгөө шагнажээ

2.11. Үндэсний хорооны дүрмийн 3.9-д “ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажилд онц идэвх зүтгэлтэй оролцсон дотоод, гадаадын байгууллага, иргэд, Үндэсний хорооны гишүүд, ажилтнуудыг шагнаж урамшуулах талаар эрх бүхий байгууллагад Үндэсний хороо санал гаргах, хорооны зүгээс мөнгөн шагнал, дурсгалын зүйлээр шагнах эрхтэй” гэж заажээ.

2.12. Гэтэл нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хэрэгжүүлсэн байгууллагын зарим албан тушаалтнууд авсан санхүүжилтээсээ өөрсдийгөө шагнасан байна. Тухайлбал:

- Дэлхийн монгол угсаатны чуулга уулзалтыг зохион байгуулахад олгосон 200,0 сая төгрөгийн санхүүжилтээс чуулга уулзалтыг зохион байгуулах хорооны дарга, нарийн бичгийн дарга нар өөрсдийгөө тус бүр 1.0 сая төгрөгөөр, зохион байгуулагчийг 927,5 мянган төгрөгөөр шагнаснаас гадна арга хэмжээг сайн зохион байгуулсан нэрийн дор ажиллагсдаа 2375,0 мянган төгрөгөөр шагнаж, нийт 5056.0 мянган төгрөг зарцуулсан байна.
- Нийслэлийн ИТХ-ын тогтоолоор 2006 онд шинээр байгуулагдсан Нийслэлийн соёл урлагийн газар буюу Улаанбаатар чуулгад “Их Монгол-800” мөнгөн шөнө арга хэмжээг зохион байгуулахад 32,0 сая төгрөг олгосноос 10.5 сая төгрөгийг 3 дүүргийн Тамгын газрыг шагнахад зарцуулсан байна. Энэ арга хэмжээ нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдаагүй байжээ.
- Үндэсний хороо бэлэг дурсгалын зориулалтаар 400 ширхэг цаг, медалион авахаар Интерпресс ХХК-тай гэрээ байгуулж Бэлгийн фондод хүлээн авч гадаад дотоодын төлөөлөгч, төрийн байгууллагад олгосон ч дахин нэг бүр нь 100,0-673,0 мянган төгрөгийн үнэ бүхий “Seiko” маркийн 100 ширхэг цагийг 14,6 сая төгрөгөөр Наран их дэлгүүрээс худалдан авч төр, засгийн тэргүүн болон УИХ, ЗГ-ын гишүүдэд тараажээ.

Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулжээ

2.13. Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн арга хэмжээний төсвөөс санхүүжилт авсан зарим байгууллага хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

2.14. МУИС-ийн Монгол хэл судлалын сургуулийн хэсэг багш нарт Монголын нууц товчоог англи хэл дээр орчуулан хэвлүүлэхэд зориулж олгосон 8,5 сая төгрөгөөс “Монголын нууц товчооны судалгаа тайлбар” эрдэм шинжилгээний бүтээлийг 300,0 мянган төгрөгөөр туурвиж хэвлүүлсэн гэх боловч хэвлүүлээгүй, номны чимэг зураг, зохиогчдод оюуны өмчийн тухай хуулиар олгох 80,0 мянган төгрөгийг зарцуулаагүй боловч зарцуулснаар тайлагнасныг нөхөн төлүүлэв.

2.15. Уран зургийн галерей “Монгол ахуй” сэдэвт үзэсгэлэнгийн зардлаас 2,7 сая төгрөгийн техник тоног төхөөрөмж худалдан авсан ч данс бүртгэлдээ тусгаагүй байсныг тусгуулав.

2.16. Үндэсний хорооны ажлын алба ойн арга хэмжээний хүрээнд 2005 онд зохиогдсон үйл ажиллагааны бичлэг, хадгалалт боловсруулалт хийхэд зориулж Sony дэлгүүрээс камер, зөөврийн компьютерийг 6,2 сая төгрөгөөр худалдан авч хэрэглэж байсан бөгөөд Үндэсний хороо татан буугдсанаар ашиглалтад байсан дээрх тоног төхөөрөмжүүдийг ТЗҮААЭГ-т хүлээлгэн өгсөн боловч 2,9 сая төгрөгийн зөөврийн

компьютерийг (засах боломжгүй, сэлбэг болох боломжтой) өөр маркаар сольж өгснийг холбогдох хүмүүсээр төлүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

2.17. Монголын урчуудын эвлэлийн хороо Дундговь аймгийн Гурван сайхан сумын нутаг дахь "Их Газрын чулуу" хэмээх газар зуны задгай театр, зууны манлай уртын дуучин Н.Норовбанзадын дурсгалын хөшөөнд олгосон 70 сая төгрөгийн санхүүжилтээс хүн амын орлогын албан татварын 1,6 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй байсныг төлүүлэв.

2.18. Үндэсний хорооны ажлын алба зарим ажил гүйлгээний санхүүжилтийг олгохдоо суутган тооцсон хүн амын орлогын албан татварын 640,7 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй байсныг төлүүлэв.

2.19. Гадаад сурталчилгаа, гадаадын сурвалжлагчдын багийг урихад МОНЦАМЭ агентлагт 39,2 сая төгрөгийн санхүүжилт олгосноос 780,0 мянган төгрөгийг зориулалт бус зүйлд зарцуулсныг нөхөн төлүүлж, 4,2 сая төгрөгөөр техник тоног төхөөрөмж худалдан авсан боловч данс бүртгэлдээ тусгаагүй байсныг тусгуулав.

2.20. Баяр наадмын ажлын хэсгийн зочин төлөөлөгчдийн байр хоол, унааны зардлын хэмнэлт 255,6 сая төгрөгөөр 6 ширхэг "Ниссан максима" маркын автомашин авахаар Үндэсний хороо шийдвэрлэж "Моннис интернейшнл" ХХК-тай гэрээ хийжээ. Ингэхдээ тендер зарлаагүй бөгөөд өмнө нь зарласан тендерт тулгуурласан буюу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34.1.3, 34.1.4-т "нэмэлт нийлүүлэлт нь анхны гэрээний үнийн 20 хувиас хэтрэхгүй нөхцөлд анхны гэрээний дагуу нийлүүлсэн барааг нэмж нийлүүлэх үед, ижил төстэй ажлыг давтан хийх тохиолдолд дахин тендер явуулснаар илүү сайн санал ирэхгүй гэж үзсэн тохиолдолд шууд гэрээ байгуулж болно" гэснийг үндэслэжээ. Гэтэл 6 дугаар сард "Моннис интернейшнл" ХХК-тай ТЗҮААЭГ, ГХЯ, ТТХГ-ын автобаазын паркийг шинэчлэхэд зориулж авсан автомашиныг худалдан авах гэрээг 256,2 сая төгрөгөөр хийсэн бөгөөд энэ дүнтэй харьцуулбал 20 хувь бус харин 100 хувь болж байна.

2.21. Баяр наадмын ажлын хэсгийн төлөвлөгөөнд Их Тэнгэр цогцолборын сантехникийн шинэчлэл, засварт 300,0 сая төгрөг төлөвлөсөн атал ЗГХЭГ-ын дарга, Сангийн сайдын хамтарсан 86/234 дүгээр тушаалаар 100,0 сая төгрөгөөр шил шаазан эдлэл, гал тогооны хэрэгсэл, зочид буудлын тавилга худалдан авахаар шийдвэрлэж, тавилга тоног төхөөрөмжийг БНХАУ-ын Бээжин хотын "Оестон" ХХК-иас 6 дугаар сарын 30-нд нийлүүлэх гэрээ байгуулж худалдан авсан гэх боловч гаалийн мэдүүлгээр 15,5 сая төгрөгийн барааг импортоор оруулж ирсэн нь тогтоогдож, бусад нь НББ-ийн анхан шатны баримтаар нотлогдоогүйн дээр гаалийн мэдүүлгээс үзвэл 7 дугаар сарын 8-наас хойш орж ирсэн байна.

2.22. Уг хөрөнгийг ТТХГ-ын ажилтнууд Бээжин хотоос авч Их тэнгэр цогцолборт ТТХГ-ын даргын 2007 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 20 дугаар албан бичгийг үндэслэн орлого авсан байна. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт хангалтгүй байна.

2.23. Аялал жуулчлалын ажлын хэсэг ойн үйл ажиллагааг сурталчлах, календарчилсан төлөвлөгөөтэй "Great Mongolia" нэртэй 2006 оны календарийг хэвлүүлэхэд зориулж 28,0 сая төгрөгийг Үндэсний хорооноос, 5 сая төгрөгийг "Бурхан халдун групп"-ээс, нийт 33,0 сая төгрөгөөр эх бэлтгэл болон хэвлэх ажлыг "SG system" ХХК-тай гэрээ байгуулан хийлгэж, нэг бүрийг нь 4800 төгрөгөөр үнэлж 6875

ширхэгийг ЗТАЖЯ-ны Аялал жуулчлалын ажлын хэсэг хүлээн авч ойн арга хэмжээнд зарцуулан, үлдэгдэл 3940 ширхэг календарийг Үндэсний хороонд өгчээ.

2.24. Үндэсний хороо дээрх календарийг “Их Монгол-800” санд хандиваар нэг бүрийг нь 17000 төгрөгөөр үнэлэн авч борлуулах үүргийг өгчээ. Тус сан 2903 ширхэг календарийг төсөвт байгууллага болон аж ахуйн нэгжид худалдсанаас 1854 ширхэгийн 31,5 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, 1049 ширхэг календарийн 17,8 сая төгрөгийн авлагатай байна. Гэтэл ойн арга хэмжээний төлөвлөгөө өөрчлөгдөн уг календарийн утга алдагдсан тул 13,3 сая төгрөгийн 781 ширхэг календарийг үнэгүй тараажээ.

2.25. Монголын урлагийн ажилтны холбоо олон улсын театрын урлагийн их наадам зохион байгуулахаар 40,0 сая төгрөгийн санхүүжилтээс 1943,0 мянган төгрөгийн ажлын хөлс, шагнал урамшлаас хүн амын орлогын албан татварт суутган тооцох 194,3 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй байсныг төлүүлэв.

2.26. УИХ-ын гишүүн, Үйлдвэр худалдааны сайд асан Б.Жаргалсайханы санаачилгаар “Их Монгол-800” олон улсын урлагийн их наадмыг зохион байгуулахаар Үндэсний хороо “Буян” ХК-тай гэрээ байгуулж 2.0 тэрбум төгрөгийг дараахь байдлаар олгожээ.

Огноо	Дүн	Зориулалт
06.06.30	650,000,000.0	санхүүжилт
06.07.07	650,000,000.0	санхүүжилт
06.08.08	400,000,000.0	санхүүжилт
06.11.06	270,000,000.0	санхүүжилт
06.11.01	30,000,000.0	санхүүжилт
	2,000,000,000.0	

2.27. Гэтэл гадаадын хамтлаг дуучдын (нийт хамтлаг дуучидтай байгуулсан 6 гэрээний нэгээс бусад гэрээг ҮХЯ-ны төрийн нарийн бичгийн дарга Д.Нямсүрэн, сайдын зөвлөх асан Т.Ганбат нар байгуулсан) болон тоног төхөөрөмжийн үнийг урьдчилан хийх шаардлагатай байсан тул ҮХЯ, АМГТХЭГ-ын Монгол шуудан банкин дахь 1100466470 болон 2600010014 тоот данс, аккредитивийн данснаас 2006 оны 5 дугаар сараас эхлэн 1,4 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн байлаа. Энэ нь төрийн байгууллага хувийн компаний өмнөөс үйл ажиллагааг хэрэгжүүлсэн үйлдэл болсон байна. /Хавсралт №1/

2.28. ҮХЯ 2006 оны 6 дугаар сарын 8-нд АМГТХЭГ-ын нэр дээр Монгол шуудан банкинд “Их Монгол 800 фестиваль” нэртэй 1100484398 тоот дансыг нээж уг дансанд тус банкнаас 342,064,207.55 төгрөгийн зээл авч тоног төхөөрөмжийн үнэд шилжүүлжээ. Энэ нь ТБУСТХ-ийн 14.1.1. “улсын төсвийн байгууллага нь зээл авах, зээл олгох, зээлийн төлбөр гүйцэтгэх, зээл хувиргахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн үйлдэл болсон байна.

2.29. “Их Монгол-800” урлагийн наадмын зардлын гүйцэтгэлийг “Буян” ХК-иар гаргуулахад дараахь байдалтай байна.

	Зориулалт	Төсөв	Гүйцэтгэл
1	Урлагийн тоглолтын зардал	1,277,256,750.0	1,194,646,661.6
2	Тоног төхөөрөмж, техник хэрэгсэл болон бусад		1,021,421,657.5
3	Аж ахуйн үйл ажиллагааны зардалд	1,012,743,250.0	874,955,814.9
	Дүн	2,290,000,000.0	3,091,024,134.0

2.30. Эдгээр арга хэмжээний зардлаас урлагийн тоглолтын болон тоног төхөөрөмжийн зардлыг зүйл тус бүрээр авч үзвэл:

2.31. Чингис хаан хамтлагийн зочид буудал болон хоолны зардалд олгосон 7,5 сая төгрөгөөс 2,3 сая төгрөгийн зардал нь кассын зарлагын баримтаас өөр нотлох баримтгүйн дээр 3,2 сая төгрөгийн зардал ҮХЯ-ны гадаад зочны зардалтай давхардаж байна.

2.32. Скүүтэрс хамтлагийн зочид буудал, хоолны зардлаас 396,4 мянган төгрөг анхан шатны баримт байхгүй, ҮХЯ-ны төсөвт зардлын гадаад зочны зардалтай мөн дүнгээр давхардаж байна.

2.33. Скорпионс хамтлагийн тоглолтын хөлсөнд гэрээний дагуу 100,0 мянган евро төлөх ёстой атал 118,3 мянган евро шилжүүлснээс 1.8 мянган евро нь ачааны зардал, 16.5 мянган евро Италийн Spasесаnоn компаниас авсан сансрын гэрэлтүүлгийн тээврийн зардал байна.

2.34. ОХУ-ын дуучин Ф.Киркоровын хоол, байрны зардалд бичсэн дүнгээс 382,1 мянган төгрөг ҮХЯ-ны гадаад зочны зардалтай давхардаж, 3625,7 мянган төгрөгийн зардал нь нотлох баримтгүй, харилцах данс болон кассын тайланд огт тусгагдаагүй байна.

2.35. Монголын хамтлаг дуучдын Хэнтий аймагт зохиосон урлагийн их наадамд зарцуулсан 18,3 сая төгрөг нь санхүүгийн анхан шатны баримтын бүрдэлд дутуу байна.

2.36. Японы эстрад, ардын урлагийн хамтлагийн онгоцны зардал гэж 3000 ам.доллар буюу 3.5 сая төгрөг кассын зарлагаас өөр нотлох баримтгүй байна.

2.37. Унгарын Твинсикс хамтлагийн замын зардал 3386,0 ам.доллар буюу 3.9 сая төгрөгийг ҮХЯ-ны төсвөөс зарцуулсан байна.

2.38. “Буян” ХХК 893,5 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг импортоор оруулж, түүнийгээ урлагийн их наадамд ашиглан улмаар соёл, урлагийн байгууллагад хүлээлгэн өгсөн, тэдгээрийг угсарч суурилуулах, тээврийн болон холболтын зардал зэрэг нэмэгдэн 935,3 сая төгрөг, Нийслэлийн захирагчийн албанд боловсон жорлон, үйлчилгээний киоск зэрэг 86,1 сая төгрөгийн тоног төхөөрөмж, бүгд 1021,4 сая төгрөгийн зардал гарсан гэж тайлагнажээ.

2.39. Импортоор оруулж ирсэн тоног төхөөрөмжийг НББ-ийн анхан шатны баримтаар тулган үзэхэд тайланд тусгагдсан 7 тоног төхөөрөмжид 1350,7 сая төгрөг буюу 457,0 сая төгрөг илүү шилжүүлсэн, төсвийн хөрөнгөөс 90,7 сая төгрөгийн, бүгд 547,7 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг тайландаа тусгаагүй байна. /Хавсралт 2/

2.40. Үндэсний хорооны даргын 2006 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 10 дугаар тушаалаар “Их Монгол” олон улсын үзэсгэлэн худалдаа, урлагийн их наадмыг зохион байгуулахад бий болсон хөгжим, техник, тоног төхөөрөмжийг бүртгэж үнэлэн харьяалагдах байгууллагыг тогтоож, зохих журмын дагуу хүлээлгэн өгөх үүрэг бүхий ажлын хэсэг тоног төхөөрөмжийг дараахь байгууллагад 2006 оны 11 дүгээр сард хүлээлгэн өгсөн байна.

2.41. Аудитын явцад “Буян” ХК уг техник, тоног төхөөрөмжийг хэрхэн хүлээлгэж өгсөн байдалтай газар дээр нь танилцлаа. Үүнд:

- 280,073.7 ам.доллар буюу 327,7 сая төгрөгийн гэрлийн тоног төхөөрөмжүүдийг ДБЭТ болон ЦДБЭЧ-д хүлээлгэж өгөөгүй,
- хөгжмийн тоног төхөөрөмжийг ЦДБЭЧ, ХБК-д бүрэн суурилуулж өгсөн, УФ-д суурилуулж өгсөн ч нэг бүр нь 4500 ам.долларын үнэ бүхий Dupacord маркын 4 ширхэг чанга яригч, 4500 ам.долларын үнэ бүхий Yamaha маркын даралтат хөгжмийн өсгөгч 1 ш, бүгд 22,500 ам.доллар буюу 26.3 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг хүлээлгэж өгөөгүй,
- ДБЭТ-т 81,485.38 ам.долларын хөгжмийн тоног төхөөрөмж хүлээлгэн өгөхөөс 59,530 ам.доллар буюу 73 хувийг нь хүлээлгэн өгсөн, бусдыг нь угсарч суурилуулахдаа хүлээлгэн өгнө гэсэн тайлбартай,
- ҮДБЭЧ-д 43,118.3 ам.долларын тоног төхөөрөмжийг суурилуулалт болон тээвэрлэлтийн зардалд 16,149.5 ам.доллар, нийт 59267.8 ам.долларын, бүжигчдийн хувцас болон материалд нийт 13,195.9 ам.долларын хөрөнгө хүлээлгэн өгөх гэрээтэй боловч 11,826.6 ам.долларын бүжгийн болон хувцасны материал хүлээлгэн өгч, хөгжмийн тоног төхөөрөмжөөс 40,105.0 ам.долларын төхөөрөмжийг ҮДБЭЧ-д бус, гэрээ байгуулаагүй УДЭТ-т өгсөн,
- Дээрх урлагийн байгууллагад хөгжмийн тоног төхөөрөмжүүдийг хүлээлгэн өгсөн гэх боловч тайлан тэнцэлд баталгаажсан дүн байхгүй, орлогод аваагүй,
- Нийслэлийн захирагчийн албанд хүлээлгэн өгсөн боловсон жорлон болон үйлчилгээний киоскийг тайлан тэнцэлдээ орлого аваагүй(одоогоор Чингэлтэй дүүргийн ТҮК-д хадгалаатай байгаа бөгөөд СХД-ийн ТҮК-д хүлээлгэн өгч тайлан тэнцэлд тусгуулна гэсэн хариу өгсөн), хүлээлгэн өгөх байгууллагаа тогтоогүй байна.

2.42. ҮДБЭЧ-д хүлээлгэн өгсөн бүжгийн хувцас чанар, эдэлгээний хувьд муу, шаардлага хангахгүй, зарим байгууллагад өгсөн хөгжмийн тоног төхөөрөмж хуучин байна гэсэн тайлбарыг мэргэжлийн хүмүүс өгснөөс гадна хөгжмийн хайрцаг дээр 23/12/2004 гэсэн огноо наалттай байсан учир УГЕГ-аас 2006 онд ҮХЯ болон “Буян” ХХК-ийн нэр дээр импортоор орж ирсэн тоног төхөөрөмжүүдийн судалгааг тодруулахад ийм тоног төхөөрөмжүүд хилээр орж ирээгүй байна.

2.43. “Их монгол 800” урлагийн их наадмыг зохион байгуулахад гадны байгууллагаас нийт 49,980.0 ам.долларын хандивын хөрөнгө цугларсныг АМГТХЭГ-ын 1100484401 тоот ам.долларын дансанд байрлуулж зарцуулсан байна.

2.44. Дээрх хөрөнгөөс БНХАУ-ын иргэн н.Өргөнд бэлнээр олгосон 8663,0 ам.доллар нь хөгжмийн кабель утас, жижиг хэрэгслүүдийг авахад зарцуулагджээ.

2.45. Герман улс руу Б.Цогтсайханы харилцах дансанд шилжсэн 11.256,8 ам.доллар буюу 8910 евро нь анхан шатны баримтгүй бөгөөд ямар тоног төхөөрөмж нь тодорхойгүй байна.

2.46. ҮХ-ны сайдын зөвлөх асан Т.Ганбат Турк улсын Yurtakalan компанитай гэрээ байгуулж 34.500,0 ам.долларыг боловсон жорлон гэсэн нэрээр шилжүүлсэн байна. Уг жорлонг Туркээс авахаар гэрээ байгуулсан боловч хугацаандаа ирээгүйгээс урлагийн тоглолтын явцад дотоодын компаниас түрээсээр ашиглаж байжээ. Уг тоног төхөөрөмжийн тээврийн зардалд 24.075 ам.доллар шилжүүлжээ.

2.47. “Их Монгол-800 фестиваль” данснаас ҮХЯ-ны нярав байсан н.Эрдэнэбат 3 удаа нийт 10,7 сая төгрөгийг чекээр авсан боловч уг мөнгийг ҮХЯ болон “Их Монгол-800 фестиваль” дансны касст орлогоор аваагүй, юунд хэрхэн зарцуулсан нь тодорхойгүй байна.

БҮЛЭГ 3

Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойг зохион байгуулах Үндэсний хорооны төсвийн хөрөнгийн зарцуулалт

Сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах шийдвэрийг Удирдах зөвлөл гаргажээ



3.1. Үндэсний хорооны 2005 оны 13 дугаар тогтоолоор Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн арга хэмжээг бэлтгэх, тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг удирдан зохион байгуулахаар тус хорооноос төлөвлөсөн арга хэмжээг санхүүжүүлэх, хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлэх иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн идэвх санаачилгыг өрнүүлэн нэгтгэх чиг үүрэг бүхий “Их Монгол-800” санг байгуулж үйл ажиллагааг нь зохицуулах сангийн дүрмийг баталжээ.

3.2. “Их Монгол-800” сан 2005 оны 11 дүгээр сарын 25-нд ХЗДХЯ-нд бүртгүүлэн 5285 дугаар бүртгэлийн гэрчилгээ авснаар Төрийн бус байгууллагын статустай болж санг Ерөнхий сайд тэргүүлэн, ЗГХЭГ-ын дарга, БХ, ЗТАЖ, БСШУ-ны сайд, ГХ-ийн болон Сангийн дэд сайд, ШУА-ийн дэд ерөнхийлөгч, Үндэсний хорооны ерөнхий зохцуулагч зэрэг удирдах зөвлөлийн гишүүдтэй ажиллаж иржээ.

“Их Монгол-800” сан хуулийн дагуу байгуулагдаагүй байна

3.3. Төрийн бус байгууллагын тухай хуулийн 4.1-д “Монгол Улсын иргэн, төрийн байгууллагаас бусад хуулийн этгээд төрийн байгууллагаас зөвшөөрөл авахгүйгээр өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс дангаараа буюу хамтран төрийн бус байгууллага байгуулах эрхтэй” гэж заасан. Гэтэл Үндэсний хороо нь Засгийн газрын тогтоолоор байгуулагдан, төсвөөс санхүүждэг төрийн байгууллага атал “Их Монгол-800 сан”-г байгуулсан нь төрийн бус байгууллагын тухай хуулийн дээрх заалттай зөрчилдөж байна.

3.4. Төрийн бус байгууллагын тухай хуулиар “Их Монгол-800” сан нь төрөөс хараат бус байх ёстой атал төрийн хяналтан дор төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилготой байгуулагдсан байна.

3.5. Иргэний хуулийн 37.1-д “Сангийн эрх барих байгууллага буюу удирдах зөвлөл нь хандивлагч, дэмжигч, тэдгээрийн томилсон төлөөллөөс бүрдэнэ” гэж заасан байтал сангийн удирдах зөвлөлд Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүд байгаа нь хуулийн заалтыг зөрчжээ.

Сангийн хөрөнгийн дийлэнх хувь төсвийн хөрөнгөөс бүрджээ

3.6. Төрийн бус байгууллагын тухай хуулийн 19 дүгээр зүйлд “сангийн хөрөнгийн эх үүсвэр нь иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хандив, зээлийн өвийн болон төсөл хэрэгжүүлэх зорилгоор улсын төсвөөс олгосон хөрөнгөөс бүрдэнэ”, мөн “Их Монгол 800” сангийн дүрмийн 5-д “хандивлагч орон, олон улсын байгууллагын буцалтгүй тусламж, хандивын хөрөнгө, байгууллага аж ахуйн нэгжийн хандивын хөрөнгөөс бүрдэнэ” гэж заажээ.



3.7. “Их Монгол-800” сан 2005 оны 12 дугаар сарын 14-нд Их тэнгэр цогцолборт нээлтээ хийж төр, засгийн тэргүүн, гадаад орнуудын элчин сайд, түр хамаарагч, олон улсын байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагаас хандив цуглуулах ажил өрнүүлснээр 122 аж ахуйн нэгж, байгууллага, 970 гаруй иргэдээс нийт 1,437,8 сая төгрөгийн мөнгөн хандив, 34.2 сая төгрөгийн үнэ бүхий бараа бүтээгдэхүүн төвлөрчээ.

3.8. Энэ үйл ажиллагааны санхүүжилтийг ТЗҮААЭГ-аас 10.0 сая төгрөгийн зээл авч хэрэгжүүлсэн бөгөөд зээлээ цугларсан хөрөнгөөсөө эргүүлэн төлжээ.

3.9. “Их Монгол-800” санд хандив өргөсөн аж ахуйн нэгж байгууллагаас 10.0 сая төгрөгөөс дээш хандив өргөсөн байгууллагыг танилцуулбал:

№	Хандивласан огноо	Хандивлагч байгууллагын нэр	/мянган төгрөг/	
			хандивын хэмжээ	Нийт орлогод эзлэх хувь
1	2005.12.23	МИАТ ХК	10,000.0	0.69
2	2005	Бурхан халдун ХХК	10,000.0	0.69
3	2006.01.16	Худалдаа хөгжлийн банк	10,000.0	0.69
4	2006.02.21	Эвсэг ХХК-иас ноолууран бүтээгдэхүүн	11,226.5	0.77
5	2006.06.16	Тайваны төлөөлөгчийн газар 10000 ам.доллар (2006.12.31-ний МБ ханшаар)	11,700.0	0.81
6	2006.07.08	Түлш эрчим хүчний яам (системийн нийт ажилчдын нэг өдрийн цалин)	44,510.5	3.07
7	2006.11.01	Онцгой байдлын ерөнхий газар ажилчдын нэг өдрийн цалин	10,192.1	0.70
8	2006.11.29	Улаанбаатар төмөр замын хувь нийлүүлсэн нийгэмлэг	100,000.0	6.90
9	2006.10.04	Эрдэнэтийн уулын баяжуулах үйлдвэр 1000.000 ам.доллар (2006.12.31-ний МБ ханшаар)	1,168,000.0	81.2
10	Дүн		1,375,629,1	
11	Нийт хандивын орлого		1,437,836.6	

3.10. “Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр”-ийн хандивын хөрөнгийг тус үйлдвэрийн удирдлагын зөвлөлөөр хэлэлцээгүй, Төрийн өмчийн хорооны даргын 2006 оны 37 дугаар албан бичгийн дагуу шилжүүлсэн байна.



3.11. Сан ойг тэмдэглэн өнгө-рүүлэх арга хэмжээний төлөв-лөгөөг олон нийтэд таниулан сурталчлах, ойн арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэр бий болгох арга хэмжээний хүрээнд Үндэсний хорооны төсвийн хөрөнгөөр ЗТАЖЯ-наас хэвлүүлсэн “Great Mongolia” хуанли 3940 ширхэгийг нэг бүрийг нь 17,0 мянган

төгрөгөөр үнэлэн хандиваар авч 1854 ширхэгийг худалдан борлуулснаас 31,5 сая төгрөгийн, нэг бүр нь 6000 төгрөгийн үнэ бүхий “Их Монгол улс” хуанли 2331 ширхэг, нэг бүр нь 2655 төгрөгийн үнэ бүхий ширээний хуанлийг бүгд 15,3 сая төгрөгөөр хэвлүүлж худалдан борлуулснаас 13,1 сая төгрөгийн, нийт 44,6 сая төгрөгийн орлого олжээ.



3.12. Сангийн удирдах зөвлөлөөс Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн бэлгэ тэмдгийг (лого) төлбөртэй хэрэглүүлэх журам баталж хэрэгжилтэд хяналт тавих үүргийг санд даалгасан ч логоны төлбөрийг хэт өндөр тогтоож борлуулалт хангалтгүй байснаас 3 удаа өөрчилж үнэ төлбөргүй ашиглуулахаар тогтжээ. Лого ашиглуулсны төлбөрийн орлогоос 3,8 сая төгрөгийн орлого олсон байна.

Сангийн хөрөнгийг зориулалт бус зүйлд зарцуулжээ

3.13. “Их Монгол-800” санд хандивын орлогоос 1460.2 сая, бүтээгдэхүүн борлуулалтаас 45.6 сая, лого ашиглуулсны төлбөрөөс 3.8 сая, банкны хүүгийн орлогоос 6.9 сая, бүгд 1516.5 сая төгрөгийн мөнгөн орлого төвлөрчээ.

3.14. Сангийн дүрмийн 10-т заасанчлан “Сангийн хөрөнгийг их эзэн Чингис хаан болон Их Монгол Улс байгуулагдсан түүхэн үйл явдлыг сурталчлах зорилгоор Үндэсний хорооноос төлөвлөсөн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулах ёстой” бөгөөд гүйцэтгэл нь дараахь байдалтай байна.

№	Зардлыг зориулалт	Дүн	Нийт дүн эзлэх хувь
1	Сангийн үйл ажиллагаа болон хандивын хөрөнгө цуглуулах, үйл ажиллагааг сурталчлахад	133,164,717.77	9,2
а	Сангийн урсгал зардалд	27,540,226,77	2,0
б	Сангийн хөрөнгийг өсгөх, сурталчлах, хандив цуглуулах арга хэмжээг зохион байгуулахад	105,624,491.00	7,2
2	Санхүүжилт хэлбэрээр олгосон дүн	1,336,383,000.00	90,8
а	Урлаг уран бүтээл туурвихад	864,150,000.00	58,8
б	Ном, CD хэвлүүлэх шагнал урамшилд	92,100,000.00	6,3
в	Хөрөнгө оруулалт буюу бүтээн байгуулалтад	355,600,000.00	24,2
г	Бусад үйл ажиллагаанд	24,533,000.00	1,7
	Нийт дүн	1,469,547,717.77	

3.15. Дээрх зардлын 90,9 хувь буюу 1336,2 сая төгрөгийг санхүүжилт хэлбэрээр, 9,2 хувь буюу 133,2 сая төгрөгийг сангийн урсгал зардал болон хандивын хөрөнгө төвлөрүүлэх үйл ажиллагаанд зарцуулжээ.

3.16. Санхүүжүүлсэн хөрөнгийн 38,9 хувь буюу 519,3 сая төгрөгийг ойг тэмдэглэн өнгөрүүлэх нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдаагүй зүйлд зарцуулах шийдвэрийг сангийн удирдах зөвлөлөөс гаргасан нь сангийн дүрмийг зөрчин зориулалт бусаар зарцуулах шалтгаан болсон байна /Хавсралт 3/. Үндэсний хорооны 2006 оны 9 дүгээр тогтоолоор баталсан Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг санхүүжүүлэх ёстой атал уг төлөвлөгөөнд тусгагдаагүй арга хэмжээг санхүүжүүлжээ. Тухайлбал: Соёлын төв өргөөний тайзны засварт 281,0 сая төгрөг олгосон байна. Гэтэл тус энэ арга хэмжээ нь нэгдэн төлөвлөгөөнд тусгаагүй байна.

3.17. Ном болон CD хэвлүүлэхэд зориулж 92.1 сая төгрөгийг зарцуулсан нь нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдаагүй байна.

3.18. Их ойн хүрээнд хийгдсэн “Тулгар төрийн товчоон” баримтат киног Үндэсний хорооноос зохион байгуулсан “Хамгийн хамгийн” цэнгүүний үед хувилж тараахад 7 сая төгрөг зарцуулж, тухайн арга хэмжээнд уригдсан хүмүүсийн бэлгэнд өгсөн бөгөөд уг киног дахин хувилж олон нийтийн хүртээл болгох зорилгоор 15.0 сая төгрөг зарцуулахаар Үндэсний хорооны мэдээлэл сурталчилгааны ажлын хэсэгт олгон 1000 ширхэг хувилжээ.

3.19. Нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдаагүй, ойн утга агуулгатай огт хамааралгүй зарим арга хэмжээг санхүүжүүлжээ. Тухайлбал, “Эрх цагаан дарь эх” ХХК-ийн бүтээх “Цагаан дарь эх буюу эзэнт төрийн хатан” нэртэй уран сайхны кинонд 40,0 сая, ШУА-ын Түүхийн хүрээлэнгээс зохион байгуулсан “Богд хаант Монгол Улс байгуулагдсаны 100 жилийн ой”-д зориулсан эрдэм шинжилгээний бага хурлын зардалд 2,2 сая, Эмэгтэйчүүдийн байгууллагаас “Монголын эмэгтэйчүүд А-Я” гэсэн ном хэвлүүлэхэд 8,7 сая, Барилга хот байгуулалтын яамны “Их хуралдайн Шар ордны макет хийлгэхэд шаардагдах зардал”-д 5,6 сая төгрөг олгосныг дурдаж болох юм.

3.20. “Цахим өртөө” ТББ-д гадаадад сурч, ажиллаж, амьдарч байгаа монгол иргэдийн нэгдсэн судалгаа хийхэд зориулж 29,0 сая төгрөгийг зарцуулахаар удирдах зөвлөлөөс шийдвэрлэсэн нь ойн үйл ажиллагаатай огт хамааралгүйн дээр төсвийн хөрөнгөөр ТББ-ын үйл ажиллагааг санхүүжүүлсэн байна.

3.21. Сангийн дүрэмд хөрөнгийг төсвийн хуулийн дагуу тайлагнана гэж заасан учир сангийн үлдэгдэл 16,0 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэх нь зүйтэй гэж үзэв.

3.22. Удирдах зөвлөлийн шийдвэрээр сангийн хөрөнгөөс зориулалт бусаар олгосон хавсралтад дурдсан аж ахуйн нэгжийг ҮТЕГ-аар шалгуулах нь зүйтэй гэж үзлээ.

Хөрөнгийн зарцуулалтад хяналт тавиагүй байна

3.23. Сангийн дүрмийн 14.2-т гүйцэтгэх захирал “сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг сонгох, гүйцэтгэгчийг тендерээр шалгаруулах ажлыг зохион байгуулж сангийн удирдах зөвлөлд танилцуулж шийдвэрлүүлэх “ гэж заасны дагуу сангийн хөрөнгөөр төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ нэг ч удаа тендер зарлаагүй байна.

3.24. Дүрмийн 14.3-т “сангийн удирдах зөвлөлөөр баталсан төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх талаар гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан гүйцэтгэлд нь хяналт тавин ажиллана”, 14.4-т “сангийн хөрөнгөөр бүтээсэн барилга байгууламж, хөшөө дурсгал,

ном зохиол, урлаг, уран бүтээлийг цаашид хариуцах газарт хүлээлгэн өгнө” гэж заасан нь сан татан буугдах тохиолдолд хэрэгжих боломжгүй болжээ.

3.25. Ойг тэмдэглэх нэгдсэн төлөвлөгөөнд нэр заан орсон зарим гүйцэтгэгч батлагдсан санхүүжилтийг бүрэн авсан боловч гүйцэтгэлээ тайлагнаагүй, ажлаа 2006 онд бүрэн дуусгаагүй байна.

3.26. Сангийн хөрөнгөөр хийгдэж байгаа Чингис хааны тухай уран сайхны кинонууд 2006 онд хийгдэж дуусаагүй, хяналт тавих ёстой сан 2007 оны 3 сарын 1-нд тайлангаа тавьж татан буугдсан гэх боловч албан ёсоор татан буулгасан шийдвэр гараагүй байна.

3.27. Эдгээр уран бүтээлийн гүйцэтгэлд хяналт тавих үүргийг их ойг тэмдэглэн өнгөрүүлэх урлаг уран бүтээлийн ажлын хэсгийг мэргэжлийн болон бодлогын талаас зохион байгуулж байсан БСШУЯ гурвалсан гэрээгээр хүлээсэн байна.

3.28. Уг гэрээнд арга хэмжээний үед бий болсон тоног төхөөрөмж, эд хөрөнгийг хэрхэх нь тодорхойгүй, уран бүтээлийг олны хүртээл болгосноос орох орлогыг төсөвт буцаан төвлөрүүлэхээр заажээ.

3.29. Тухайлбал, Монгол Японы хамтарсан Чингис хаан кинонд Соёл урлагийг хөгжүүлэх сангаас 434,0 сая, Их Монгол-800 сангаас 255,0 сая, бүгд 689,5 сая төгрөгөөс 411,5 сая төгрөгийн хувцас хэрэглэл, Монголын уран бүтээлчдийн бүтээж буй Чингис хаан киноны санхүүжилтэд 480,0 сая төгрөг олгосноос 151,3 сая төгрөг нь камер, кран, гэрлийн тоног төхөөрөмж, хувцас хэрэглэл нь тухайн киног бүтээхэд оролцсон найруулагч, продюсерийн багт хөрөнгө хэлбэрээр үлджээ.

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, баримт материал, хийсэн судалгаа, дүн шинжилгээнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.

- Төлөвлөгөөнд тусгагдсан зарим ажил ойн арга хэмжээний үндсэн зорилготой тэр бүр уялдаагүй байна.
- Үндэсний хороо ойн арга хэмжээг төлөвлөхдөө хичнээн төгрөгийн зардал гарч, олох орлогыг үндэслэлтэй тооцоогүйн гадна гэрээт ажлын санхүүжилт оройтож хийгдсэн зэргээс ямар хугацаа шаардагдах, гүйцэтгэлийг хэрхэн дүгнэх талаар хангалтгүй ажилласнаас зарим ажил хугацаандаа хийгдээгүй байна.
- Үндэсний хороо дүрмийнхээ дагуу ойн арга хэмжээг төлөвлөх, батлах, гүйцэтгэгчийг томилон ажиллуулах, холбогдох байгууллагаар шийдвэр гаргуулах, хуваарилсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, хөтөлбөр төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавиагүйгээс санхүүжилт авсан байгууллагууд төсвийн хөрөнгөд үрэлгэн ханджээ.
- Үндэсний хороо Төрийн бус байгууллагын тухай хуулийн 4.1 дэх заалтыг зөрчин “Их Монгол-800 сан”-г байгуулжээ.
- “Их Монгол-800” сангийн хөрөнгийн 38,9 хувь буюу 548,3 сая төгрөгийг зориулалт бус зүйлд зарцуулсан байна.
- Үндэсний хороо болон “Их Монгол-800” сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн зарим арга хэмжээний үр дүнд ТББ-д бий болсон хөрөнгийг хэрхэн талаар удирдах зөвлөлөөс ямар нэгэн шийд гараагүй бөгөөд санг албан ёсоор татан буулгасан шийдвэр ч мөн алга байна.

Холбогдох байгууллагын санал



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2007 он 10 дугаар
сарын 30 ны өдөр

Дугаар ... 207/2173


Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧ Б.БАТБАЯР ТАНАА

Тайлбар хүргүүлэх тухай

"Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойг зохион байгуулах Үндэсний хорооны төсвийн хөрөнгийн зарцуулалт"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтөй танилцаад холбогдох тайлбар, саналыг бэлтгэн хавсралтаар хүргүүлж байна.

Тайлбар болон саналтай танилцаад аудитын тайланд тусгах арга хэмжээ авна уу.



Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга

 С.БАТБОЛД

“Их Монгол Улс байгуулагдсаны 80 жилийн ойг зохион байгуулах Үндэсний хорооны төсвийн хөрөнгийн зарцуулалт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай холбогдуулан өгөх санал

Нэг. Төлөвлөгөөнд тусгагдсан зарим арга хэмжээнүүд ойн арга хэмжээний үндсэн агуулгатай уялдаагүй тухайд

Аудитын тайлангийн төслийн 1.7-д “80 тохой Майдар бурхны хатгамалд 80.0 сая төгрөг зарцуулсан бөгөөд түүнийг сүм хийд, сүсэгтнүүд хийх боломжтой байсан” гэжээ.

Үндэсний хороо ойн арга хэмжээний төлөвлөгөө боловсруулахдаа иргэд, байгууллага, хамт олноос ирүүлсэн санал санаачилга дээр тулгуурласан бөгөөд зөвхөн их эзэн Чингис хаан, Их Монгол Улсыг хамрах хүрээнд бус түүнээс хойшхи үеийн түүх соёл, уламжлалыг ч хамруулахыг зорисон.

Шарын шашин нь Монголын төрийн үүрэгт тодорхой байр суурь эзэлж байх үедээ төр-шашны томоохон ёслолдоо зориулж 80 тохой Майдар бурхныг бүтээсэн байна.

Эдгээрийг үндэс болгож “Монгол хатад” клубээс Үндэсний хороонд тавьсан саналын дагуу 26 метр өндөртэй, 17 метрийн өргөнтэй, зээгт наамалын аргаар 3 жилийн турш бүтээсэн бүтээлийн зарим хэсгийг Үндэсний хороо санхүүжүүлэх болж, Ой тэмдэглэх ажлын төлөвлөгөөнд тусгасан болно. Энэхүү зээгт наамал нь нийт 400 гаруй сая төгрөгийн өртөгтэй бүтээгдсэн тооцоог урлаачид гаргасан байна.

Иймд “80 тохой Майдар” үнэт бүтээл нь 800 жилийн ойн ойн арга хэмжээтэй уялдаа холбоогүй гэсэн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй байна.

Мөн 80 тохой Майдар бурхны хатгамал нь улсын өмчид бүртгэгдэн одоо Дүрслэх урлагийн музейд зориулалтын байранд, XIX, XX зууны үед бүтээгдсэн бусад том хэмжээний зурмал, зээгт наамал бурхадын хамт хадгалагдаж байгаа тул тайланд уг хөргийг зохих ёсоор хадгалах байр байхгүй гэснийг хасах. Харин хөрөнгө санхүүгийн бэрхшээлийн улмаас олон нийтэд дэлгэн харуулах байрны асуудлыг шийдвэрлэх боломжгүй байгаа юм. Гэхдээ урлагийн үнэт бүтээлийг олон нийтэд байнга дэлгэн харуулах нь уг бүтээлийн чанар хийгээд, үнэт байдалд сөргөөр нөлөөлдөг тул түүнийг голчлон зориулалтын газарт хадгалан, хэрэгцээтэй цагт дэлгэн үзүүлдэг болохыг анхаарах бизээ.

Тайлангийн төслийн 1.8-д дурдсан “Дундговь аймгийн задгай театр, зууны манлай уртын дууч Н.Норовбанзадын дурсгалд зориулсан хөшөөнд 70.0 сая төгрөг зарцуулсан. Үүнийг соёл урлагийг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх боломжтой байсан” тухайд:

Тайлбар
2-ыг үзнэ үү

Тайланд “Дундговь аймгийн задгай театр” гэснийг Дундговь аймгийн Гурван сайхан сумын нутаг дахь “Их Газрын чулуу” хэмээх газар зуны задгай театр байгуулах гэж өөрчлөх нь зүйтэй байна.

Мөн “Их Газрын чулуу” хэмээх түүхэн газар зуны задгай театр байгуулан, зууны манлай уртын дуучиндаа зориулан хөшөө босгох ажлыг Үндэсний хороо санхүүжүүлэн, зохион байгуулсан нь 800 жилийн ойн арга хэмжээтэй уялдаа холбоогүй болжээ гэж дүгнэснийг хүлээн зөвшөөрөх боломжгүй байна.

Тайлбар 3-
ыг үзнэ үү

Тайлангийн төслийн 1.9-д Их тэнгэр цогцолборын сантехникийн засварт зориулан төсөвлөсөн 300.0 сая төгрөгөөс тус цогцолборт вакум цонх хийлгэсэн гэсэн дүгнэлтийг хасах саналтай байна. Учир нь 1.9-д дурдсан ажил нь Төрийн тусгай хамгаалалтын газрын 2006 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаж хийгдсэн ажлууд бөгөөд Их ойн төлөвлөгөө, төсөвт тусгагдсан Их тэнгэр цогцолборын сантехникийн засварын 300.0 сая төгрөгийн төсөвтэй огт хамааралгүй юм. /Уг асуудлаар Төрийн тусгай хамгаалалтын газраас Үндэсний аудитын газарт нэмэлт тайлбар өгч байгаа болно/

Тайлбар 4-
ийг үзнэ үү

Тайлангийн төслийн 1.10-т “гадаадын зочин төлөөлөгчдөд үйлчлэхээр ГХЯ, ТЗУААЭГ, ТТХГ-ын автобаазад авах автомашин авах хөрөнгөөр төрийн өндөр албан тушалтнуудын албан ажлын болон хөдөө ажлын автомашин худалдан авахад зарцуулсан тухайд:

Их ойд уригдсан гадаадын хүндэт зочин төлөөлөгчдийн ая тухтай зочлох таатай нөхцөлийг бүрдүүлэх, найдвартай тохилог уналга машинаар үйлчлэх, аюулгүй байдлыг бүрэн хангахын тулд шаардлага хангасан автомашинтай болох явдал чухал байсан юм. Үйлчилгээнд явж байсан автомашинууд нь 10-16 жил ашиглагдсан 180-362 мянган км зам туулсан, өнгө үзэмж, марк, загвар хуучирч муудаад тухайн орондоо үйлдвэрлэгдэхээ больсон, өндөр хэмжээний зочны айлчлалын үеэр нэг бус удаа унтарч зогсож байсан машинууд байсан тул ГХЯ, ТЗУААЭГ, ТТХГ-ын автобаазуудын парк шинэчлэлт хийх зайшгүй шаардлагатай болсон. Ийнхүү ТЗУААЭГ, ТТХГ, ГХЯ-ны авто баазын паркийг шинэчилснээр зочдын ая тухтай байдлыг хангаад зогсохгүй олон жил хуримтлагдсан хүндрэлтэй асуудлыг нэг мөр шийдвэрлэх боломжтой болсон юм.

Зочдод үйлчлэх унаагаар автопаркийг шинэчлэх ажил нь Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрээр, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжсэн бөгөөд худалдан авсан автомашинаар төрийн өндөр хэмжээний зочин, төлөөлөгч болон бусад зочдод үйлчилж байгаа болно.

Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйн авто бааз нь Их ойн зочны үйлчилгээнд зориулан 13 автомашин авснаас 3 нь зочин үйлчилгээнд, 10 автомашин нь албан ажлын хэрэгцээнд явуулж байна. Гэхдээ төр, засгийн өндөр хэмжээний болон бусад зочин

төлөөлөгчид ирэх үед эдгээр албаны автомашинуудаа татан оролцуулж байгаа болно.

Харин Төрийн тусгай хамгаалалтын газрын автобааз болон Гадаад хэргийн яамны автобааз гадаадын зочид, төлөөлөгчдөд үйлчлэх зориулалтаар авсан автомашинуудаа зориулалтын дагуу өндөр хэмжээний зочин төлөөлөгчдийг ирсэн үед ашиглаж байгаа болно.

Зарим арга хэмжээ товлосон хугацаандаа дуусаагүй талаар

Тайлангийн төслийн 1.13-т заасан зарим ажил, үйчилгээ хугацаандаа хэрэгжээгүй байгаа тухайд:

Үндэсний хорооны ажлын албанаас гэрээ байгуулан, Төрийн түүхийн музейд хүлээлгэн өгөх ёстой 275.2 сая төгрөгийн 9 арга хэмжээнд зориулан олгосон мөнгөний тайлан тооцоог хийх, ажлыг хүлээн авах талаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газраас тодорхой ажлуудыг хийж байна. Одоогоор жагсаалтад дурдсан найман ажлаас 2, 3, 6, 7-д заагдсан ажлыг музейд хүлээн авсан ба бусад ажлуудыг энэ онд багтаан хүлээн авахаар гүйцэтгэгч нартай тохиролцон, протокол үйлдэн хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна. Төрийн 9 их бэлгийг Монголын Урчуудын эвлэлийн хорооны 20-иод урчууд гүйцэтгэсэн бөгөөд одоогоор эмээлээс бусад нь дууссан болно.

Монгол цэргийн зэр зэвсгийн үзмэрийн хувьд биет үзмэрүүдийг цуглуулан Төрийн түүхийн музейд хүлээлгэн өгсөн. Харин цахим үзмэрийн программ боловсруулалт хараахан дуусаагүй байгаа юм.

Жагсаалтын 8-д дурдсан Монгол төрийн түүхийн бодит цомгийн хувьд, нийтийн тооллын өмнөх III зуунаас 1945 он хүртэлх он цагийн хэлхээ, холбогдох зургийг эмхлэн цомгийн эх бэлтгэх ажлыг гүйцэтгэж байгаа бөгөөд энэ оны 12 дугаар сарын 15-ны өдөр бэлэн болгосон байна гэж гүйцэтгэгч тал мэдэгдэж байгаа. Уг ажлын санхүүжилт оройтож /2006.06.12/ хийгдсэн, уг ажил нь өөрөө цаг хугацаа шаардсан нүсэр ажил тул хугацаандаа амжаагүй байна.

Жагсаалтад дурдсан эдгээр ажил нь хугацаа хожимдсон тодорхой шалтгаан байсан болно. Тухайлбал: 1/ Эрдэмтэдийн судалгаа бүрэн хийгдэхэд цаг хугацаа шаардлагатай, 2/ Эдгээр үзмэрүүдийг цахим хэлбэрт оруулах хугацааг бүүруу тооцсон, 3/ бэлтгэсэн үзмэрээ хэл зүй, найруулга зүй, түүхэн үндэслэлийг шалгаж нягтлахад ихээхэн цаг орсон, 4/ эдгээр зүйлийг бүтээхэд 50-иад эрдэмтэд оролцсон учир тэдний цаг завьг зохицуулахад хүндрэлтэй байсан зэрэг болно. Гэхдээ эдгээр үзмэрийг байршуулах Төрийн түүхийн музей ашиглалтад ороогүй байгаа тул хугацаа хожимдсоны хор хохирол төдий л байхгүй юм. /төрийн түүхийн музейн үзмэрийг хүлээн авсан баримтыг хавсаргав/

Жагсаалтын 9-д дурдсан "Миний түүх, миний соёл" танин мэдэхүйн нэвтрүүлгийн хувьд, Монголын түүх, соёлын хосгүй өв уламжлал, нүүдлийн зан заншлыг хойч үедээ өвлүүлэн үлдээх зорилгоор Монголын Урлагийн зөвлөл санаачлан, Монголын Үндэсний олон нийтийн телевизийн Хүүхэд, Залуучуудын редакцтай хамтран Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн төсвийн санхүүжилтээр хүүхдийн телевизийн нэвтрүүлэг бэлтгэн орон даяар /одоо ч гэсэн/ нэвтрүүлж байна.

2007 оны 10 дугаар сарын 28-ны байдлаар нийт 56 цуврал нэвтрүүлгийг 5 булантайгаар бэлтгэн, Ням гараг бүр МҮОНТВ-ээр нэвтрүүлсэн байна. Уг нэвтрүүлэг нь үргэлжилж байгаа учир хугацаандаа хэрэгжээгүй гэж үзэх боломжгүй байна. /Уг төсөлтэй холбоотой Монголын Урлагийн зөвлөлөөс ирүүлсэн тайлбар, танилцуулгыг хавсаргав/

Хоёр. Төсвийн хөрөнгөд үрэлгэн ханджээ гэсэн бүлэгт

Үндэсний хороо хөрөнгийн зарцуулалт хяналт тавиагүй байна гэсэн талаар:

Тайлангийн төслийн 2.6-д тусгагдсан "Өүлэн эх" дуурь хугацаандаа тавигдаагүй бөгөөд "Их Монгол 800 сан"-гаас нэмэлт хөрөнгө зарцуулсан тухайд, уг дурийн санхүүжилт оройтож шийдэгдсэн болон хөгжмийн зохиолч нь хөгжмөө гүйцэд дуусгаагүйн улмаас цаг хугацаа алдсан байна. Уг дуурийг бүтээх явцад нэмэлт хөрөнгийн асуудал зайлшгүй гарч ирсэнийг Дуурь бүжгийн эрдмийн театр болон хөгжмийн зохиолчийн зүгээс Үндэсний хороонд тавьсан бөгөөд Үндэсний хороо өмнө нь 25.0 сая төгрөг зарцуулсан учир уг дуурийг дуусган нийтэд толилуулах үүднээс нэмэлт хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх асуудлыг Үндэсний хорооны 2006 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн уг хөрөнгийг "Их Монгол 800 сан"-гаас санхүүжүүлэх хүсэлтийг санд тавьсан байна. Дуурь хугацаандаа болон гэрээний үнийн дүнд багтаагүйн хариуцлагыг холбогдох этгээдэд тооцох үүргийг Үндэсний хорооны 2006 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар Үндэсний хорооны Урлаг, уран бүтээлийн ажлын хэсэгт өгсөн байна.

Тайлбар 6-г
үзнэ үү

Тайлангийн төслийн 2.9-д тусгагдсан дүрсжүүлсэн баримт хуулах "PROLOK-ARRI" аппаратур чанарын шаардлага хангахгүй учир комисс хүлээн авах боломжгүй гэж дүгнэсэн талаар бид уг аппаратыг худалдан оруулж ирсэн "Шастир танхим" ББН-өөс холбогдох тайлбарыг гаргуулан авсан болно. Уг аппаратын хурдыг тогтворжуулах зориулалттай тэжээлийн блокыг ХБНГУ-ын "ARRI" компанид захиалан авчруулж, үндсэн аппаратад суурилуулах ажлыг хийж байгаа юм байна. Ийнхүү суурилуулснаар уг аппарат шаардлагыг бүрэн ханган ажиллах боломжтой болох бөгөөд 12 дугаар сарын 15-ны дотор хүлээлгэн өгнө гэж мэдэгдсэн болно. /"Шастир танхим" ББН-өөс ирүүлсэн тайлбарыг хавсаргасантай танилцана уу/

Тайлангийн төслийн 2.10-т тусгагдсан асуудлын хувьд: Төрийн түүхийн музейн аппаратур, цахим тоноглол худалдан

авахаар зарласан тендерт "Оргил софт" ХХК ялж гэрээ байгуулсан бөгөөд, гэрээний ажлууд хугацаандаа хэрэгжиж байна.

Тайлбар 7-г
үзнэ үү

Төрийн түүхийн музейн объект ашиглалтад ороогүйн улмаас гэрээг эцэслэн дүгнээгүй байна. Санхүүжилтийн үлдэгдэл 30% нь санхүүжигдээгүй байгаа бөгөөд ТЗҮААЭГ-аас энэ оны есдүгээр сард "Оргил софт" ХХК -тай гэрээний явцыг дүгнэж, хугацааг сунгасны зэрэгцээ зарим нэг нийлүүлэгдээгүй төхөөрөмжийн үнийн зөрүүг тооцож 15.0 сая төгрөгийн нэмэгдэл бараа, техник хэрэгсэл авахаар болоод байна. Гэрээ бүрэн хэрэгжих нөхцөл бүрдсэн.

Төсвийн хөрөнгөөр өөрсдийгөө шагнажээ гэсэн тухай:

Тайлбар
8-ыг үзнэ үү

Энэхүү дэд гарчиг болон 2.12-т "тухайн байгууллагын албан тушаалтнууд өөрсдийгөө шагнасан байна" гэсэн нь Үндэсний хороо, түүний ажлын алба өөрсдийгөө төсвийн хөрөнгөөр шагнасан мэт ойлгогдохоор байгааг залруулах. Учир нь уг гарчгийн дор тайланд дурдсан дүгнэлтээс үзвэл Үндэсний хороо, түүний ажлын албаныхан өөрсдийгөө шагнасан гэсэн дүгнэлт байхгүй байна.

Мөн Төсвийн хөрөнгөөр өөрсдийгөө шагнажээ гэсэн гарчгийн дор "ЗГХЭГ-ын дарга С.Батболд цаг худалдан авч, төр, засгийн тэргүүн болон УИХ, Засгийн газрын гишүүдэд тараасан байна" гэж дүгнэсэн нь ойлгомжгүй байгаа бөгөөд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга нь өөрөө дур мэдэн худалдан авч, албан тушаалтнуудад зүгээр л тараасан мэтээр ташаа ойлгогдож байх тул үүнийг залруулах хэрэгтэй байна.

Уг цагнуудыг Их Монгол Улс байгуулагдсаны 800 жил, Ардын хувьсгалын 85 жилийн ой, Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах Үндэсний хорооны зүгээс Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Ерөнхий сайд болон Улсын Их Хурал, Засгийн газрын гишүүд, албаны бусад хүмүүсд дурсгал болгон худалдан авсан бөгөөд Үндэсний хорооны Баяр наадам, зочин хүндэтгэлийн арга хэмжээнд төлөвлөн, Үндэсний хорооны тогтоолоор баталгаажуулж, Үндэсний хорооны даргын 2006 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 2 дугаар тушаалаар шийдвэрлэж, Төрийн ёслолын албанаас зохион байгуулсан төлөвлөгөөтэй, шийдвэртэй, зохион байгуулалттай арга хэмжээ байсан юм.

Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн хаалтын арга хэмжээ болгон шинэ жилийн баярт зориулж "Их Монголын мөнгөн шөнө" нийтийн цэнгүүнийг 2006 оны 12 дугаар сарын 31-ний орой Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулсан бөгөөд цэнгүүнийг зохион байгуулахад шаардагдах нийт 62.0 сая төгрөгөөс 32.0 сая төгрөгийг Ойн арга хэмжээний зардлын төсвийн баяр наадам, зочин хүндэтгэлийн арга хэмжээний зардлын хэмнэлтээс гарган санхүүжүүлэхээр Үндэсний хороо шийдвэрлэсэн болно. Дээрх

хөрөнгийг уг арга хэмжээнд зориулан оролцсон хамтлаг, дуучид, найруулагчийн хөлсөд олгосон байгааг "Төсвийн хөрөнгөөр өөрсдийгөө шагнажээ" гэж томьёлон нэрлэх нь зохимжгүй байна.

Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зурцуулжээ гэсэн тухайд:

Тайлангийн төслийн 2.16-д тусгагдсан Уран зургийн галерейгаас 935.7 мянган төгрөгийг нөхөн төлүүлж, 2.7 сая төгрөгийн техник тоног төхөөрөмжийг данс бүртгэлд тусгуулах тухайд, Уран зургийн галарейн ихэнх үзмэрүүд нь хананд өлгөдөг зураг байдаг бөгөөд Орон нутгаас ирсэн музейн үзмэрүүдэд зориулан тавиур, хорго, гэрэлтүүлэх прожектор, үзмэрийн заалны прожектор, дэлгэц, компьютер авсан бөгөөд Үндэсний аудитын газраас ирүүлсэн албан тоотын дагуу шинээр авсан хөрөнгийг хөрөнгийн бүртгэлд тусгах ажлыг гүйцэтгэсэн байна. Түүнчлэн аудитын тайланд тусгагдсан хэтрэлт/хэмнэлт гэснийг төсвийн гүйцэтгэлд хэмнэлт 1026520 төгрөг, хэтрэлт 90820 төгрөг гэж тодруулж байна. Иймээс хэмнэснийг ч, хэтэрснийг ч нийлүүлж 935.7 төгрөгийн акт тавьсан нь учир дутагдалтай болсон гэж үзэж байгаа юм байна. Уран зургийн галарей нь актыг хүлээн авсан даруйдаа нөхөн төлөх хөрөнгийг төслсөн гэж бидэнд мэдэгдсэн болно. /Уран зургийн галарейн ирүүлсэн албан бичигтэй танилцана уу/

Тайлангийн төслийн 2.17-д тусгагдсан зөөврийн компьютер өөр маркаар солигдсон тухай асуудлыг холбогдох хүмүүсээс тодруулан үзвэл, Үндэсний хорооны ажлын албаныхан 2006 оны 3 дугаар сард Увс, Ховд, Баян-Өлгий аймагт ажлаар явахдаа шинээр авсан компьютерийг ашиглаж байсан бөгөөд хөдөө замд болсон автомашины ослын улмаас уг компьютер эвдэрч гэмтсэн гэж тайлбарлаж байгаа. Ашиглаж байсан компьютерээ санаатай эвдээгүй, автомашины ослын улмаас эвдэрсэн бол буцаан төлүүлэх тухай асуудал байхгүй учир эвдэрсэн ч гэсэн уг компьютерийг буцааж авчирах шаардлагыг бидний зүгээс тавьж байгаа болно.

Тайлбар
9-ийг үзнэ
үү

Тайлангийн төслийн 2.20-т "ЗГХЭГ-ын дарга нь тушаал гаргаж, Засгийн газрын 2006 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 157 тогтоолоор баталсан "Гааль болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөх бараа материал, машин механизмын нэр төрөл, тоо хэмжээний жагсаалт"-д автомашины тоо 3 байсныг 16 болгон өөрчилсөн" гэснийг хасах саналтай байна. Учир нь ЗГХЭГ-ын дарга нь Засгийн газрын тогтоолыг тушаал гарган өөрчлөх эрх мэдэл, боломж байгүй бөгөөд Засгийн газрын 2006 оны 281 дүгээр тогтоолоор дээрх 157 дугаар тогтоолд өөрчлөлт оруулж 3 ширхэг Ниссан Максима машиныг 16 болгон нэмэгдүүлсэн юм.

Түүнчлэн Баяр, наадмын ажлын хэсгийн зочин төлөөлөгчдийн байр, хоол, унааны зардлын хэмнэлтээс 6 ширхэг автомашин авах асуудлыг ЗГХЭГ-ын дарга дангаар шийдсэн асуудал биш бөгөөд Үндэсний хороонд танилцагдаж, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжсэн ажил болно.

Тайлбар
10-ыг үзнэ
үү

Мөн тайлангийн төслийн 2.21-д "Моннис интернейшнл" ХХК-иас машин авахдаа тендер зарлаагүй гэснийг дэмжих боломжгүй. Учир нь Үндэсний хороо автомашин худалдан авахтай холбоотой бүхий л ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хуулийн хүрээнд зохион байгуулсан. Уг хуулийн 34.1.3, 34.1.4-т "нэмэлт нийлүүлэлт нь анхны гэрээний үнийн 20 хувиас хэтрэхгүй нөхцөлд анхны гэрээний дагуу нийлүүлсэн барааг нэмж нийлүүлэх үед, ижил төстэй ажлыг давтан хийх тохиолдолд дахин тендер явуулснаар илүү сайн санал ирэхгүй гэж үзсэн тохиолдолд шууд гэрээ байгуулж болно" гэж заасныг үнэдсэлсэн болно.

Тайлангийн төслийн 2.22, 2.23-т заасан дүгнэлтийн хувьд, Төрийн тусгай хамгаалалтын газраас тодруулан асуухад дараахь тайлбарыг өгсөн болно. Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ой, Үндэсний их баяр наадмын үеэр ирсэн өндөр хэмжээний зочид төлөөлөгчдөд зориулан Их тэнгэр цогцолборын 50-ын 1 дүгээр байр, 50-ын 3 дугаар байр, 30 дугаар байрны тавилгыг солих шаардлагатай болсон тул шаардлагатай хөрөнгийг гаргаж өгөхийг хүссэн. Сангийн яам нэмэлт хөрөнгө гаргах боломжгүй, харин Их тэнгэр цогцолборын сантехникийн шинэчлэл, засварт зориулан Үндэсний хорооны төсөвт тусгасан 300.0 сая төгрөгийн зардлаас 100.0 сая төгрөгийг тавилга, бусад эг хогшилд зарцуулж болох юм гэсэн чиглэл өгсөн тул ЗГХЭГ-ын дарга, Сангийн сайдын хамтарсан 86/234 дүгээр тушаал гарч уг асуудлыг шийдвэрлэсэн болно. Холбогдох байгууллагуудтай гэрээ байгуулж, ажил үүргийг зохих хугацаанд нь хийж гүйцэтгэсэн бөгөөд шинээр бий болсон бараа материалыг нягтлан бодох бүртгэлийн холбогдох данс бүртгэлд бүрэн тусгасан болно. /Дээрх тайлбартай холбоотой нэмэлт тайлбар, танилцуулгыг ТТХГ нь Үндэсний аудитын газарт танилцуулах болно/

Улсын Их Хурлын гишүүн, Үйлдвэр худаалдааны сайд асан Б.Жаргалсайханы санаачилгаар зохион байгуулсан "Их Монгол 800" олон улсын урлагийн их наадамтай холбогдуулан аудитын тайланд тусгагдсан дүгнэлттэй танилцаад Үйлдвэр, худалдааны яамнаас манайд ирүүлсэн тайлбарыг хавсралтаар хүргүүлж байна.

Мөн уг арга хэмжээг зохион байгуулсан "Буян" компани аудитын тайланд тусгагдсан асуудлын талаарх тайлбараа өөрсдөө Танай газарт гаргаж өгөх юм.

Түүнчлэн "Их Монгол 800 сан"-гийн ажлын алба Аудитын тайлантай холбоотой тайлбараа манайд ирүүлэлгүй удсан тул хуулийн хугацаанд аудитын тайлангийн тухай саналаа өгөх үүднээс энэхүү танилцуулгад орхигдсон болно. "Их Монгол 800 сан"-гийн ажлын алба өөрсдөө холбогдох тайлбараа хүргүүлэх болно.

---оо0оо---

UNION
FOR PEACE AND FRIENDSHIP
MONGOLIA



МОНГОЛЫН ЭНХ ТАЙВАН,
НАЙРАМДЛЫН ТӨЛӨӨ
ХОЛБОО

Date 2007.10.31
No 87

Ulaanbaatar

УИХ-ЫН ГИШҮҮН, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА,
ИХ МОНГОЛ УЛС БАЙГУУЛАГДСАНЫ 800 ЖИЛИЙН ОЙН
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ОРЛОГЧ ДАРГА Сү.БАТБОЛД ТАНАА

Тайлбар хүргүүлэх тухай

2006 онд Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойг тэмдэглэх хүрээнд Дэлхийн монгол угсаатны Чуулган (ДМУЧ)-ыг зохион байгуулахтай холбогдуулан батлагдсан төсвийн зарцуулалтын талаар Үндэсний Аудитийн шалгалтын дүгнэлтэд өгөх тайлбарыг хавсралтаар хүргүүлж байна.



ЕРСНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

ДБИЛЭГТ

Peace and Friendship House, Peace avenue 17a, Ulaanbaatar 210644, Mongolia.
Tel: (976-11)-323456, Fax: (976-11)-320045. E-mail: peacemongolia@yahoo.com
www.peacemongolia.org

УИХ-ЫН ГИШҮҮН, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА, ИХ
МОНГОЛ УЛС БАЙГУУЛАГДСАНЫ 800 ЖИЛИЙН ОЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ
ОРЛОГЧ ДАРГА Сү.БАТБОЛД ТАНАА

Аудитийн шалгалтын
дүгнэлтэд өгөх тайлбар

Санхүүжилт авсан тооцоо нийлсэн тухай

Монголын Энх тайван, Найрамдлын Холбоо (ЭТНМХ) нь Дэлхийн монгол угсаатны Чуулган (ДМУЧ)-ыг зохион байгуулахтай холбогдсон мөнгөн санхүүгийн төсвийн төслийг 18.3 мянган ам.доллар буюу тухайн үеийн Монгол банкны ханшаар 216,9 сая төгрөгөөр тооцоолон гаргаж, Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойг тэмдэглэх Үндэсний хорооны Ажлын албанд хүргүүлж, улмаар Үндэсний хорооны хурлаар хэлэлцүүлж, Чуулганы зардлын төсвийг 200 сая төгрөгөөр батлуулж, захиран зарцуулах эрхийг тус Чуулганыг Зохион байгуулах Хороонд өгсөн болно.

Зохион байгуулах Хороо /ЗБХ/ батлагдсан төсвийн санхүүжилтийг Эрэл-2 банкинд ДМУЧ-ы нэр дээр төгрөгийн 2119015 тоот данс нээж хийж байсан ба Үндэсний хорооноос эхний ээлжинд 50.0 сая төгрөгийн санхүүжилтийг 2006 оны 5 дугаар сарын 23-ны өдөр авсан, 2-р ээлжинд 2006 оны 6 дугаар сарын 29-нд 50,0 сая төгрөг, 2006 оны 7 дугаар сарын 24-нд 75.0 сая төгрөгийг авч ДМУЧ-ы арга хэмжээнүүдийг санхүүжүүлсэн болно. Үлдсэн 25.0 сая төгрөгийг Үндэсний хорооны Ажлын албанаас төсвийн гүйцэтгэлийг эцэслэн гаргасны дараа шилжүүлнэ гэсний дагуу 2006 оны 9 дүгээр сард төсвийн урьдчилсан гүйцэтгэлийг 199,045,943 төгрөгөөр гаргаж санхүүгийн тайлан, холбогдох анхан шатны баримтын хамт тус Ажлын албанд хүргүүлж хянуулан, тооцоог нийлсэн.

Ажлын албанаас 2006 оны 12 дугаар сарын 7-ны өдөр 18 сая төгрөгийн санхүүжилтийг өгч, батлагдсан төсвөөс 7,0 сая төгрөгийг дутуу олгосон.

Ингэснээр манай Зохион байгуулах хороо ДМУЧ-ыг зохион байгуулах ажилд батлагдсан 200 сая төгрөгийн төсөвт зардлаас 193 сая төгрөгийг санхүүжилтээр авч зарцуулсан ба энэ тухай санхүүгийн тайланг холбогдох баримт материалын хамт Үндэсний хорооны Ажлын алба, Үндэсний Аудитийн шалгалтын холбогдох хүмүүсээс өгсөн зөвлөмжийн дагуу гаргаж 2007 оны 1 дүгээр сарын 29-ний өдрийн 04 тоот албан тоотоор хүргүүлсэн болно.

Зохион байгуулах Хорооны тухай

Монголын Улсын Ерөнхийлогч Н.Энхбаярын ивээл дор Дэлхийн монгол угсаатны Чуулганыг зохион байгуулах нийт ажлыг Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх Үндэсний хорооны 2006 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн 07 тоот тогтоолын дагуу 48 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан Дэлхийн монгол угсаатны Чуулганыг Зохион байгуулах Хороонд /Хавсралт №1/

даалгасан юм. ЗБХ-ны анхдугаар хурлаар уг хорооны даргаар Д.Цахилгаан, Ерөнхий зохицуулагчаар Б.Энхтүвшин, Нарийн бичгийн даргаар Д.Билэгт нарыг томилон ажиллуулсан ба Чуулганыг батлагдсан хөгөлбөр, төсвийн дагуу зохион байгуулж явуулах, санхүүжүүлэх ажлыг ЗБХ-ны шийдвэрээр гүйцэтгэсэн. Иймд уг Чуулганыг Энх тайван, Найрамдлын төлөө Монголын Холбоо (ЭТНМХ) биш Дэлхийн монгол угсаатны Чуулганы Зохион байгуулах Хороо бүхэлд нь удирдсан болно. Тийм ч учраас ЗБХ, уг Хорооны дарга удирдлагын шийдвэр, тушаалын дагуу төсвийн зарцуулалтыг хийж гүйцэтгэсэн болно.

Тайлбар гаргах нь

Үндэсний Аудитийн Газраас ДМУЧ-ыг зохион байгуулахтай холбогдуулан хийсэн дүгнэлтэнд дараах тайлбарыг огч байна.

1. “Дэлхийн монгол угсаатны чуулган”-ыг зохион байгуулах бүхий л үе шатны ажилд ЭТНМХ-ны Нарийн бичгийн дарга нарын газар (НБДГ)-ын ажилтан нарыг бүрэн бүрэлдэхүүнээр нь 2006 оны эхнээс эхлэн татан оролцуулж, Чуулганыг бэлтгэх нүсэр их ажлыг цаг наргүй, ихээхэн хүч, хөдөлмөр, чармайлт гаргаж нугалсан нь Чуулганы ажиллагааг амжилттай явуулахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн юм. ЭТНМХолбоо нь ТББ учир улсын төсвөөс санхүүждэггүй, өөрийн хөрөнгөөр, үйл ажиллагаа явуулдаг, НБДГ-ын цоон тооны ажилтнууд энэхүү арга хэмжээг өөрийн үндсэн ажил үүргээс хэд дахин илүү хүч хөдөлмөр гарган хийж гүйцэтгэснийг харгалзан үзэж, батлагдсан төсвийн 1,2 хувь буюу 2 сая 375 мянган төгрөгийг ЗБХ-ны даргын 2006 оны 8 дугаар сарын 25-ны 01 тоот шийдвэрээр ажилласны нь хөлс болгон урамшуулал хэлбэрээр олгосон. /Хавсралт №2/
2. ДМУЧ-ыг зохион байгуулах асуудал анхлан тавигдсанаас эхлэн Үндэсний хорооны баталсан төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу олон улсын энэ томоохон арга хэмжээг гардан зохион байгуулах, бичиж боловсруулах, зохицуулах нүсэр ажлыг нуруун дээрээ үүрч, Чуулганыг өндөр үнэлгээтэй хийсэн төдийгүй одоо амжилттай ажиллаж байгаа олон улсын төрийн бус байгууллагыг шинээр үүсгэн байгуулж, Монгол улсын Гадаад бодлого, үйл ажиллагааны нэн чухал шинэ чиглэлийг Ардын дипломатын гольдролд оруулахад үнэнхүү ихээхэн хүч чармайлт, идэвх зүтгэл, санаачилга гарган бодитой, үр бүтээлтэй ажилласныг харгалзан ЗБХ-ны дарга Д.Цахилгаан, Нарийн бичгийн дарга Д.Билэгт нарыг ЗБХ-ны 2006 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 04 тоот шийдвэрээр тус бүр 1 сая төгрөгийн урамшлыг олгосныг Д.Цахилгаан, Д.Билэгт нар өөрөө өөрсдийгөө шагнасан явдал гэж гуйвуулах үндэслэлгүй байна. /Хавсралт №3/
3. Чуулганы ажилд татан оролцуулсан бусад хүмүүст олгосон 927500 төгрөгийн тухайд гэвэл, Баримт бичгийн боловсруулах болон Зохион байгуулалтын ажлын хэсгүүдэд орчуулагч, хэлмэрч, хөтөч зэргээр 1-3 сараар ажилласан, 10 гаруй хүмүүст ажлын хөлсийг нь урамшил нэрээр олгосон. /Хавсралт №4/
4. Ер нь ДМУЧ-ыг зохион байгуулах ажилд оролцсон нэг ч хүнд ажилласны хөлсийг “цалин” гэж өгөөгүй. Харин ТББ-уудад нийтлэг хэрэглэдэг шагнал, урамшлын хэлбэрээр олгосон болно.

5. Нөгөөтэйгүүр, ДМУЧ-ыг зохион байгуулахад гаргасан санхүүжилт нь улсын төсвийн хөрөнгө бус төр засаг, олон нийт аж ахуйн байгууллага, хувь хүмүүсийн хандиваар бүрдүүлсэн тусгай сангаас санхүүжүүлсэн хөрөнгө гэж бид ойлгож байгаа.
6. Монгол Улсын Засгийн газар, Их ойг тэмдэглэх Үндэсний хороо Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойг тэмдэглэх ажлын хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярын ивээл дор зохион байгуулсан ДМУЧ-ыг өндрөөр үнэлж, ойн хүрээнд зохиосон олон зуун ажил бүтээл, төслийн дотроос “Хамгийн хамгийн шилдэг”-ээр шалгаруулж, “Хамгийн өнөр Хурилдай” Алтан гэрэгэ өргөмжлөл хүртээсэн билээ. Энэ явдал Чуулганыг ЗБХ-ны ажлыг төр засгаас тод томруун үнэлсэн хэрэг бөгөөд энэ ажилд хүч хөдөлмөрөө зориулсан нэр бүхий хүмүүст зохих хэмжээний шан урамшил, ажлын хөлс олгосон нь нийтлэг жишиг, зүйн дагуу хийсэн ажил гэж үзнэ.
7. Иймийн учир, үйл ажиллагаагаа амжилттай дуусгавар болгоод татан буугдсан ДМУЧ-ы ЗБХ-ны шийдвэрээр тухайн цагт ёс номын дагуу олгогдсон 5 сая гаруй төгрөгийн шагналыг Үндэсний Аудитийн Газрын шалгалтын дүгнэлтэнд дурьдсанчлан, ЭТНМХ-нд тохох, улсын төсвийн мөнгөөр шагнал явуулсан гэж буруутгах учиргүй гэж үзэж байна.

ДМУЧ-НЫ ЗБХ-НЫ ДАРГААР АЖИЛЛАЖ АСАН,
ЭНХ ТАЙВАН, НАЙРАМДЛЫН ТОЛОО
МОНГОЛЫН ХОЛБООНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ



Д.ЦАХИЛГААН

ДМУЧ-НЫ ЗБХ-НЫ
НАРИЙН БИЧГИЙН ДАРГААР АЖИЛЛАЖ АСАН,
ЭНХ ТАЙВАН, НАЙРАМДЛЫН ТӨЛӨӨ МОНГОЛЫН
ХОЛБООНЫ ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Д.БИЛЭГТ

Үндэсний Аудитийн Газарт2007 оны 11 дугаар
сарын 15-ны өдөрДугаар *04/142*

Улаанбаатар хот

Тайлбар өгөх тухай

“Их Монгол Улс 800” жилийн ойг тэмдэглэх ажлыг зохион байгуулах Үндэсний хороо нь 2006 оны 6 дугаар тогтоолоороо “Их Монгол-800” олон улсын урлагийн их наадмыг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж, Монгол Улсын Үйлдвэр Худалдааны Яам зохион байгуулагчаар нь ажилласан. Тухайн үед ҮХЯ-ны сайдаар (тус компанийн ерөнхий захирал байсан) Б.Жаргалсайхан ажиллаж байсан учраас “Буян” ХХК урлагийн их наадмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор оролцсон. “Буян” ХХК нь “Их Монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойг тэмдэглэх ажлыг зохион байгуулах” Үндэсний Хороо-той байгуулсан “Их Монгол-800” олон улсын үзэсгэлэн худалдаа, урлагийн их наадам зохион байгуулах тухай 55 тоот гэрээний дагуу Гүйцэтгэгчээр ажилласан юм.

“Буян” ХХК нь “Их Монгол – 800” олон улсын үзэсгэлэн худалдаа, урлагийн их наадам зохион байгуулсан тухай ажлын тайлан, санхүүжилтийн гүйцэтгэлийн тайлан, холбогдох санхүүгийн баримт материалуудыг тухай бүрд нь Үндэсний Аудитийн Газарт өгсөн бөгөөд Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойг зохион байгуулах Үндэсний Хорооны төсвийн хөрөнгийн зарцуулалтын тайлангийн холбогдох зарим заалтуудад дараахи тайлбарыг өгч байна. Үүнд :

1. Урлагийн их наадмыг зохион байгуулах Ажлын хэсгийн ахлагчаар ҮХЯ-ны сайд (асан) Б.Жаргалсайхан ажиллаж ҮХЯ-ны хэмжээнд “Их Монгол улс байгуулагдсаны 800 жилийн ой” арга хэмжээг тэмдэглэх Ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон ҮХЯ-ны зохих албаны хүмүүс гадаадын хамтлаг, дуучидтай тоглолтын гэрээ байгуулсан нь эрх хэмжээний хүрээнд хийгдсэн асуудал болно. Хавсралт, ҮХЯ-ны сайдын тушаалын хуулбар

2.Гадаадын хамтлаг, дуучид нь тоглолтын төлбөр төлөгдсөн болон хөгжмийн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хүчин чадлыг нь харгалзан гэрээ байгуулж, тоглолтоо хийдэг олон улсын хэм хэмжээний дагуу үйл ажиллагаагаа явуулахад санхүүжилт зайлшгүй хэрэгтэй байсан учраас ҮХЯ (АМГТХЭГ) –аас санхүүжилт авч шийдвэрлэсэн билээ. Хэрвээ Төрийн сангаас төсөвлөсөн санхүүжилт төлөвлөсөн хугацаандаа орж ирсэн бол ийм асуудал гарахгүй байсан билээ. Төрийн сангаас орж ирсэн санхүүжилтийг тухай бүрд нь тооцооны дагуу ҮХЯ (АМГТХЭГ) –ны дансанд шилжүүлсэн.

3.“Их Монгол -800 “ урлагийн наадмын зардлын гүйцэтгэл 2007 оны 10 дугаар сарын 31-ны байдлаар :

Зориулалт	гүйцэтгэл	төсөв
Урлагийн тоглолтын зардал	1 194 646 661.6	1 277 256 750.0
Төр засаг, нийслэл, соёл урлагийн байгууллагад хүлээлгэн өгсөн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл бусад	1 055 877 081.1	
Үйл ажиллагааны зардал	874 955 814.9	1 012 743 250.0
Нийт	3 125 479 557.6	2 290 000 000.0

Үүнээс 2 000 000 000 төгрөг нь улсын төсвөөс үлдсэн 1 125 479 557 төгрөг нь “ Буян “ ХХК-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн.

Улсын төсвийн 2 000 000 000 төгрөгийн санхүүжилтийн хувьд 1 055 877 081.1 төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, техник хэрэгслийг соёл урлагийн болон төр захиргааны байгууллагад нийлүүлж, 1 194 646 661.6 төгрөг нь урлагийн тоглолтын зардалд зарцуулагдсан бөгөөд 250 523 742.7 төгрөгийн санхүүжилт нь “Буян “ ХХК-иас хийгдсэн.

4.ХБНГУ-ын “ Чингис хаан “ хамтлагийн тоглолтын хөлсөнд 180 000 евро, ОХУ-ын дуучин Ф.Крикоров болон түүний бүжгийн хамтлагийн хөлс, чартер онгоцны хөлсөнд 280 000 ам.долларыг тус тус олгохоор гэрээ байгуулсан. Дэлхий дахинаа нэр алдар бүхий хамтлаг, дуучдын зах зээлийн тоглолтын өртөг, ханш өндөр, тоглолтын гэрээ, хуваариа урьд онд нь хийж баталгаажуулдаг. “Их Монгол-800 “ урлагийн их наадамд оролцсон Chinghis Khan, Scorpions, Scooter хамтлаг, ОХУ-ын дуучин Ф.Киркоров, М.Распутина нар нь дэлхий дахинаа нэр алдар нь түгсэн алдартай хамтлаг, дуучид гэдэгтэй хэн бүхэн санал нийлэх байх.Эдгээр хамтлаг,дуучид нь “Их Монгол-800 “ урлагийн наадамд оролцох урьдчилсан төлөвлөгөөгүй байсан, манай орны хувьд зах зээлийн ханшаар тоглох эдийн засаг, санхүүгийн боломжгүй байсан боловч Ажлын хэсгийн ахлагч Б.Жаргалсайханы хүчин

Тайлбар
11-ийг үзнэ
үү

чармайлтын дүнд энэ алдартай хамтлаг, дуучид " Их Монгол -800 " жилийн ойн арга хэмжээнд өөрсдийн тоглолтоороо оролцсон явдал Монгол орны нэр хүндийг олон улсын урлагийн тавцанд өндөр өргөсөн түүхэн тэмдэглэлт явдал болсон гэж үзэж байна. Наадмын санхүүжилтийн эх үүсвэр хугацаандаа орж ирээгүйгээс " Чингис хаан " хамтлагт урьдчилгаа 80 000 евро шилжүүлж, үлдсэн 100 000 евро болон Суучин Ф.Крикоровт тоглолтын хөлс 280 000 ам.долларыг бэлнээр олгосон болно. Тоглолтын гэрээ бол төлбөр хийх үндсэн баримт болно.Хавсралт, Chinghis khan хамтлаг, Ф.Крикоровтой байгуулсан тоглолтын гэрээний хуулбар,

Тайлбар
12-ыг үзнэ
үү

5.ХБНГУ-ын " Scorpions " хамтлагийн хөлсөнд гэрээний дагуу 100 000 евро шилжүүлэхээс 118 300 евро шилжүүлсэн гэж үзжээ. Үүнд: 100 000 евро нь Scorpions хамтлагийн тоглолтын хөлс, 1800 евро нь хамтлагийн жүжигчдийн гартаа авч ирсэн жижиг техник хэрэгсэлийн ачааны төлбөр, үлдсэн 16500 евро нь италийн Спасесаноп компаниас авсан сансарын гэрэлтүүлэгчийн (20 тонны 1 чингэлэг 1х3970 EUR, 40 тонны 2 чингэлэг 1х6800 EUR , 1х 5730 EUR) тээврийн зардал болно.Хавсралт, М&М тээвэр зуучлалын компанийн нэхэмжлэхийн хуулбар, Туушин компанийн тээврийн хөлс төлсөн тодорхойлолт

Тайлбар
13-ыг үзнэ
үү

6.Монголын хамтлаг, дуучдын тоглолтын зардалд нийт 21 691 853 төгрөг зарцуулсан. " Их Монгол-800 " жил урлагийн наадмын хүрээнд Хэнтий аймагт зохион байгуулагдсан наадмын ажиллагааны зардал тусгагдсан. Нийт зардал 18 295 565 төгрөг болсон бөгөөд энэ зардалд 40 тонны 2 ширхэг контейнертэй хөгжим, гэрэлтүүлэгийн тоног төхөөрөмжүүд, дизель станц болон арга хэмжээнд оролцсон хамтлаг, дуучид, техникийн ажилчдын тээврийн зардал, угсралт тохиргооны зардал, хоол хүнс, тэнд ажиллагсдын цалин хөлс бүгд багтсан юм. Мөн Монголын хамтлаг, дуучдын урлагийн тоглолтын дараа "Чингис зочид" буудалд хүлээн авалт хийсэн зардал 872 528 төгрөг болсон. Хавсралт, " Чингис хаан ЗБЦ" ХХК, хүлээн авалтын нэхэмжлэх,тооцооны хуудасны хуулбар

Тайлбар
14-ийг үзнэ
үү

7.Дээр тэмдэглэсэнчилэн ҮХЯ-ны хэмжээнд урлагийн наадмыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийн ахлагчийн хувиар ҮХЯ-ны сайд (асан) Б.Жаргалсайхан зарим нэгэн хамтлаг, дуучдыг хүлээн авч хүндэтгэл үзүүлсэн. Тухайлбал : Чингис хаан хамтлагийн 3.2 сая төгрөг, Scooter хамтлагийн 396 400 төгрөг, Ф.Крикоровын 382 100 төгрөг нь оройн хоолны үнэ болно.

8. " Их Монгол-800 " урлагийн их наадмын зориулалтаар орж ирсэн хөгжим, гэрэлтүүлэгийн тоног төхөөрөмжүүд нь задгай талбайн зориулалттай техник

хэрэгсэлүүд юм. Үүнд : 309 892 евро буюу 472 275 720 төгрөгийн үнэ бүхий 8000 ваттын хүчин чадалтай 28 ширхэг сансарын прожектор Space capon. Энэ прожекторыг соёл, урлагийн байгууллагууд ашиглах боломжгүй учраас оронд нь тэдгээр байгууллагуудад ашиглагддаг тайзны зориулалттай хөгжим, гэрэлтүүлэгийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэлүүдийг нийлүүлэх төслийн дагуу ХБК, ЦДБЭЧ, ҮДБЭЧ, УДТ, ДБЭТ, МУФ зэрэг байгууллагуудад нийлүүлсэн. Өнөөдрийн байдлаар тайланд дурьдагдсан ХБК , ЦДБЭЧ, УДЭТ -т хөгжмийн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг бүрэн хүлээлгэн өгч суурилуулсан. МУФ, ДБЭТ-т хүлээлгэн өгөх зарим хөгжмийн тоног төхөөрөмжүүдийг монтаж, тохиргоо хийхдээ нийлүүлэхээр, ЦДБЭЧ, ДБЭТ-ийн гэрэлтүүлэгийн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг тоглолтын хуваарийн ачаалал тэдгээр байгууллагын хүсэлтийг харгалзан нийлүүлж суурилуулах хугацааг харилцан тохиролцож хойшлуулсан болно. МУФ, УДБЭТ –д монтаж тохиргоо хийхдээ нийлүүлэхээр тохиролцсон хэрэгсэлүүдийг, УДБЭТ ,ЦДБЭЧ-т гэрэлтүүлэгийн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг 2007 оны 12 дугаар сарын 15-ны дотор нийлүүлж, монтаж, угсралтын ажлыг гүйцэтгэж дуусгана. Хавсралт, УДБЭТ, ЦДБЭЧ-аас ирүүлсэн албан тоотын хуулбар

9.Урлагийн их наадмын арга хэмжээний зориулалтаар импортоор орж ирсэн 1 350.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж, техник хэрэгслээс 547.7 сая төгрөгийн барааг тайландаа тусгаагүй гэжээ. Импортоор орж ирсэн барааны үнийн дүнд соёл, урлагийн 5 байгууллага, нийслэл, төр захиргааны 2 байгууллагад нийт 1 055,8 сая төгрөгийн барааг актаар хүлээлгэн өгсөн. 294.9 сая төгрөгийн бараа нь урлагийн арга хэмжээг зохион байгуулахад шаардлагатай хөгжим, гэрэлтүүлэгийн тоног төхөөрөмж, техник хэрэгслүүдийн жижиг эд анги, сэлбэг хэрэгсэлүүд байсан учраас тайланд тусгаагүй болно. ,

10.ҮДБЭЧ -ийн хувцасны дизайнерайн гаргасан загвар, зургийн дагуу дизайнертай нь хамт жүжигчидийн хувцасны үндсэн, туслах материалын сонголтыг хийсэн ба ажлын ачаалал ихтэй, оёдолчин хүрэлцэхгүй байгаа гэдэг шалтгаанаар оёх боломжгүй гэсэн учраас тус компани оёдолчид хөлслөн "Адуучин", "Чичиргээ", "Тоохуу" бүжгийн эрэгтэй, эмэгтэй хувцас, " Футура Фейшн " ХХК-иар 120 ширхэг гутал хийлгэсэн. Хөгжимчдийн хувцасны материал болон илүүдэл материалуудыг хүлээлгэн өгсөн болно.

11.Жүжигчдийн хувцас, материал болон хөгжмийн тоног төхөөрөмж, техник хэрэгслийг хүлээлгэн өгөх, хүлээн авах явцад ямар нэгэн гомдол санал гаргаагүй,

харин ч соёл, урлагийн байгууллагад шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслийг нийлүүлж байгаад талархаж байгаагаа илэрхийлсэн санал хүсэлтийг "Их Монгол 800" үндэсний хороонд ирүүлж байсан.Хавсралт, УДБЭТ, ЦДБЭЧ,МУФ, ХБК –оос ирүүлсэн албан тоот

12.Их наадмыг Хүй долоон худагт хийхээр төлөвлөж тэнд зориулан Турк улсаас орж ирсэн үйлчилгээний зориулалтаар ашиглах зөөврийн тоноглогдсон ариун цэврийн эр, эм жорлон, үйлчилгээний киоскыг Нийслэлийн захирагчийн ажлын алба, Төр, Засгийн үйлчилгээ аж ахуйн газруудад олгосон болно. Төр, Засгийн үйлчилгээ аж ахуй эрхлэх газарт олгосон 2 ширхэг ариун цэврийн үнэ 34 455 423.6 төгрөгийг тайланд нэмж тусгуулах саналтай байна. Хавсралт, Төр засгийн үйлчилгээ аж ахуйн газарт нийлүүлсэн төхөөрөмжийн актууд

Тайлбар
15-ыг үзнэ
үү

13.Их наадмын үйл ажиллагааг дэмжиж гадны байгууллагаас орж ирсэн хандивын хөрөнгөнөөс:

а) БНХАУ-ын Soundking, Yeeda electric suzhou компаниас кабель утас, залгуур, мульти кабель зэрэг жижиг хэрэгсэлүүдийг БНХАУ-ын иргэн Өргөнөөр дамжуулан худалдаж авсны төлбөрт 8683 ам.долларыг бэлнээр олгосон. Хавсралт ,Soundking, Yeeda electric Suzhou компанийн захиалга, үнийн санал, нэхэмжлэхийн хуулбар

б) Antari Lighting and Effects компаниас авсан 8 ширхэг 1000W гэрлийн лампын үнэ 1344 ам.доллар, 2 ширхэг тохируулагч төхөөрөмж Ice machine AC-230V үнэ 590 ам.доллар, тээврийн зардал 1320 ам.доллар, нийт 3254 ам.доллар болсон.Хавсралт,Antari Lighitng Effect компаниас авсан гэрлийн лампын үнийн нэхэмжлэх,барааны дагалдах баримтын хуулбар

в) Туркын Dorce компаниас авсан ариун цэврийн 00, үйлчилгээний киоскыг Турк улсын ачаа тээврийн Yurttakalan компаниар тээвэрлүүлсэн (Турк – Казакстан-УБ-Казакстан-Турк) 2 машины тээврийн хөлс 24000 ам.доллар болсон. Хавсралт, Туркын тээврийн Yurttakalan компанийн тээврийн баримт, үнийн нэхэмжлэх

г)ХБНГУ, Б.Цогтсайханы харилцах дансанд шилжүүлсэн 8910 евро буюу 11256.8 ам .доллар нь гэрэлтүүлэгч төхөөрөмжийн холбох хэрэгсэлүүдийн үнэ болно.

д)Урлагийн их наадмыг " Хүй долоон худаг " хэмээх газарт зохион байгуулахаар төлөвлөж байсны дагуу Турк улсаас боловсон ариун цэврийн 00 авахаар гэрээ байгуулсан .Гэтэл төлөвлөгөө өөрчлөгдсөн тул нэгэнт гэрээ байгуулж, төлбөр хийгдээд ороод ирсэн ариун цэврийн 00-г зохих байгууллагуудад өгсөн тухай дээр

тэмдэглэсэн болно. Санхүүжилт төлөвлөсөн хугацаандаа ороогүйгээс барааны төлбөр хугацаандаа хийгдээгүй учраас төхөөрөмжүүд хугацаандаа ирж чадаагүй хугацаа хоцорч ирсэн учраас Улсын төв цэнгэлдэх хүрээлэн болон Сүхбаатарын талбайд "Буян" ХХК, Их Монгол ХХК-иас ариун цэврийн 00 авч ашигласан.

"Буян" ХХК нь Монголдоо задгай талбай, тайзны хөгжим, гэрэлтүүлэг, дэлгэцийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэлээрээ нэгдүгээрт ордог, урлагийн шоу тоглолт зохион байгуулах туршлагатай, гадаад, дотоодын олон хамтлаг, дуучдын тоглолтыг зохион байгуулсан. Үүнд: Монголын дуучин Т.Ариунаа, С.Жавхлан, "Хөх тэнгэр", "Харанга", "Чингис хаан", "Номин талст" хамтлаг, ОХУ-ын дуучин Филипп Крикоров, Алсу, Швейцарийн дуучин D J BoBo, Ямайкагийн Boney M, Германы Modern Talking, Nazaret хамтлаг ... гэх мэт болно. Энэ тоглолтуудыг зохион байгуулснаар Монголд эстрадын урлагийг шинэ шатанд хөгжүүлэх, залуучуудын эстрадын урлагийг үзэх үзлийг дээшлүүлэхэд багахан боловч хувь нэмэр оруулж байгаа гэж үзэж байна. "Их Монгол-800" олон улсын урлагийн их наадмыг зохион байгуулах ажлын хэсгийн ахлагчаар Б.Жаргалсайхан тухайн үед ҮХЯ-ны сайдаар (тус компанийн ерөнхий захирал байсан) ажиллаж байсан учраас "Буян" ХХК урлагийн их наадмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор Гүйцэтгэгчээр нь оролцсон гэдгээ дахин тэмдэглэж байна. Санхүүжилт нь хугацаандаа орж ирээгүй байтал урлагын наадмын гжиллагаа эхлэх хугацаа нь тулсан гадаадын хамтлаг, дуучдын тоглолт төлөвлөсөн хугацаандаа хийгдэхгүй, хугацаа хойшлогдох болон үүнээс уламжлан гарах хүндрэл бэрхшээл, мөн аж ахуйн үйл ажиллагааны аливаа асуудлыг Ажлын хэсгээс шуурхай шийдвэрлэсний үндсэн дээр их наадам төлөвлөсөн хугацаандаа амжилттай зохион байгуулагдсан гэж үзэж байна.

Хавсралт: 35 хуудас



Ерөнхий захирал

Б.Батсайхан

Үндэсний
аудитын
газар

Холбогдох байгууллагуудаас авсан саналд үндэслэн дараахь тайлбарыг өгч байна.

Тайлбар 1

2001 онд МУ-ын Ерөнхийлөгчийн 118 дугаар зарлигаар 2006 оныг Их Монгол улс байгуулагдсаны 800 жилийн ой, төр ёсны их баяр болгон тэмдэглэсүгэй гэж зарлиг болгож Чингис хааны нэр алдар, төр түүхэн үйлсийг тэмдэглэлт ойгоор дурсахыг уриалсан.

Гэтэл уг бүтээл нь урлагийн ба шашны бүтээл бөгөөд 2006.06.11-нд бурханыг залах үйл ажиллагаа Улаанбаатар хотод болсон. Уг бүтээлийг анх Геннисийн номд бүртгүүлэх зорилготойгоор 26 м х17 м харьцаатай хийсэн байна.

Бүтээлийг МУ-ын ЗГ хүлээн авахад Их Монгол-800 сангаас 1,5 сая төгрөгийг нөхөн гаргасан бөгөөд Уран зургийн галарейд түр хадгалуулахаар өгсөн бөгөөд журмын дагуу хадгалах байр одоогоор байхгүй учир тайланд хэвээр үлдээв.

Тайлбар 2

Саналыг хүлээн авч тайлангийн 1.8-д тусгав.

Тайлбар 3, 4

Саналыг хүлээн авч тайлангаас хасав.

Тайлбар 5

Аудитын явцад дуусаагүй байсан бөгөөд зарим ажил одоо болтол дуусаагүй тул хэвээр үлдээв.

Тайлбар 6

Уг аппаратыг худалдан авч нийлүүлсэн “Шастир танхим” ББН-ийн захирал Ч.Чимэд Үндэсний хорооны ажлын албанд гэрээт ажилчнаар ажиллаж байсан бөгөөд тендерийн үнэлгээний комиссын бүрэлдэхүүнд орсон байсан. Энэ нь төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар заасан сонирхлын зөрчил үүсгэж байсан учир хүлээн авах боломжгүй. Уг аппаратыг 12 дугаар сарын 15-ны дотор хүлээлгэн өгнө гэсэн тайлбар ирүүлсэн боловч өгөөгүй байна.

Тайлбар 7

Саналыг хүлээн авч тайлангийн 2.10-т тусгав.

Тайлбар 8

Саналыг хүлээн авч утгын хувьд найруулга хийж 2.11, 2.12-т тусгасан. Нийслэлийн ИТХ-ын тогтоолоор 2006 онд шинээр байгуулагдсан Улаанбаатар чуулгад “Их Монгол-800” мөнгөн шөнө арга хэмжээг зохион байгуулахад 32,0 сая төгрөгийн төсөв батлагдсан нь нэгдсэн төлөвлөгөөнд

тусгагдаагүй.

Тайлбар 9, 10

Саналын дагуу тайлангийн 2.10-т тусгав.

Тайлбар 11

Саналыг хүлээн авч 2.34-т тусгав.

Тайлбар 12

Саналыг хүлээн авч 2.33-т тусгав.

Тайлбар 13

Санхүүгийн анхан шатны баримт нь хангалтгүй учир хүлээн авах боломжгүй.

Тайлбар 14

Хүлээн авах боломжгүй. Эдгээр зардал нь ҮХЯ-ны зочны зардлаас гарсан болно.

Тайлбар 15

Саналыг хүлээн авч тайлангийн 2.44, 2.46-д тусгав.

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дараахь албан тушаалтанд зөвлөж байна

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Энхболдод

- Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний дагуу хийгдэх ажил, үйлчилгээг 2007 онд багтаан дуусгах арга хэмжээ авч, биелэлтийг тооцон, хөрөнгийн асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэх;
- “Их Монгол-800” санг албан ёсоор татан буулгаж, сангийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийн эзэмшигчийг зохих журмын дагуу тогтоож, хүлээлгэн өгөх, шилжүүлсэн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих;
- Ой тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдсон нэг удаагийн арга хэмжээний төсвийг цаашид тодорхой төсвийн ерөнхийлөн захирагчид хариуцуулан, зарцуулалтад нь хяналт тавьж байх.

ТЗҮААЭГ-ын дарга Ж.Бадраад

- Ой тэмдэглэн өнгөрүүлэх ажлын алба, Их Монгол сангийн санхүүгийн баримт материалыг хүлээн авч архивт хадгалах

**Их Монгол-800 урлагийн тоглолтын хамтлаг дуучид, тоног төхөөрөмжид
ҮХЯ-наас урьдчилсан шилжүүлсэн хөрөнгийн судалгаа**

№	Зориулалт	евро	Ам.доллар	юань	Төгрөг
1	Хамтлаг дуучдын хөлс	155,700.0	-	-	306,965,776.49
а	Чингис хаан	87,400.0			132,415,837.70
б	Скорпионс хамтлаг	68,300.0			102,833,566.1
в	Хамтлаг дуучдын тээврийн Зардалд	47,616.0	-		71,716,372.7
2	Тоног төхөөрөмж	536,284.6	71,000.0	1,487,572.0	1,099,803,735.2
	Ултралайт тайзны гэрэлтүүлэгч тоног төхөөрөмж	118,323.4			177,377,727.56
а	Spase сапон гэрэл	309,892.0			472,275,720.0
б	Динакорд хөгжим тоног /төх	30,000.0			45,300,900.0
в	Картель Турк	24,339.0			28,720,020.0
г	Ейрнокс Турк	18,200.0			21,476,000.0
д	Дорсе ариун цэврийн ОО		71,000.00		83,070,000.0
е	SFAT industrin эфффектийн тоног төхөөрөмж	13,225.2			19,419,880.0
ё	Flash art Герман	22,305.0			33,077,760.3
ж	Хятад салют			1,487,572.00	219,085,727.4
3	Банкны шимтгэлд				1,790,014.5
	Нийт дүн	691,984.55	71,000.00	1,487,572.00	1,408,559,526.19

“Их Монгол-800 фестиваль” нэртэй 1100484398 тоот дансны зарцуулалт

№	Зориулалт	Евро	Ам доллар	Төгрөг
1	Динакорд хөгжмийн тоног төхөөрөмж	161,200.0		242,860,585.0
2	Дорсе ариун цэврийн ОО		50,000.0	58,700,000.0
3	Yurttakalan компани		34,500.0	40,503,000.0
	Нийт дүн	161,200.0	84,500.0	342,063,585.0

Үндэсний аудитын газар

Их Монгол-800 урлагийн нээдмийн төсвийн хөрөнгөөр худалдан авсан тоног төхөөрөмжийн судалгаа

№	нийлүүлэгч байгууллага	тоног төхөөрөмжийн нэр	Тайлангаар гаргах өгсөн				Санхүүгийн баримтаар талархсон дүн				Зөрүү үнэмлээ						
			унэмлээ		унэмлээ		унэмлээ		унэмлээ		3 ам доллар		4 амь				
			€ евро	₮ төгрөг	€ евро	₮ төгрөг	€ евро	₮ төгрөг	€ евро	₮ төгрөг	€ евро	₮ төгрөг	€ евро	₮ төгрөг			
1	Браво саптон	309,892.00		309,892.00	471,469,689.00		471,469,689.00										
2	Doneo		60,000.00			68,700,000.00			121,000.00					71,000.00			83,070,000.00
3	Flash art	22,306.00		22,306.00	33,077,757.40		33,077,757.40										
4	Em audio	118,860.80		118,860.80	179,120,939.50		179,120,939.50	191,166.41						72,276.61			109,040,546.00
5	Ultrafile	29,261.20		29,261.20	43,747,163.40		43,747,163.40	118,323.47						88,742.27			133,630,564.16
6	Blat	13,226.00		13,226.00	19,799,340.30		19,799,340.30										
7	БНХАУ ШИ 7thang Ping				689,026.60		689,026.60					1,487,572.00				688,546.00	131,294,662.85
	Дүн	493,894.00	60,000.00	553,894.00	883,666,964.10	654,911.88	121,000.00	1,487,572.00	1,487,572.00	161,017.88	71,000.00	888,546.50	109,040,546.00	161,017.88	71,000.00	888,546.50	457,035,772.61
Төсвийн хөрөнгөөс																	
90,689,020.00																	
	Eticks and mid evy					18,200.00								18,200.00			21,476,000.00
	Kartal plast					24,334.00								24,334.00			28,720,020.00
	Yurtalaan Turx DU					34,600.00											40,603,000.00
	хандивын хөрөнгөөс																55,304,601.30
	Yurtalaan Turx DU					24,075.00								24,075.00			28,167,790.00
	Artan lighting and effects ltd					3,254.00								3,254.00			3,807,180.00
	Баярзацдын Цогсайхан					8,910.00								8,910.00			13,170,661.30
	БНХАУ-ын ирлэн Ерлөнд					8,683.00								8,683.00			10,169,110.00
	Дүн	493,894.00	60,000.00	553,894.00	883,666,964.10	663,821.88	167,012.00	1,487,572.00	1,487,572.00	169,927.88	107,012.00	888,546.50	603,039,393.61	169,927.88	107,012.00	888,546.50	146,003,621.30

Их Монгол 800 сангийн зардлын гүйцэтгэл

Д/д	Шийдвэр		Байгууллага	Зардлын товч утга	Дүн	Тайлбар	Үндэсний хорооны төлөвлөгөөнд
	Огноо	Дугаар					
1	2005.11.11	14	Их Монгол 800 сан	Сангийн үйл ажиллагаатай холбоотой зардалд Үйл ажиллагааны зардал	27,540,226.77	СУЗ-ийн тогтоолтой	
2	2005.11.11	14	Их Монгол 800 сан	Хандивын хөрөнгө босгох, ойн арга хэмжээг сурталчлах арга хэмжээ	11,323,333.00	СУЗ-ийн тогтоолтой	
3	2006.02.20	2	Бурхан халдун групп	"Их Монгол Улс" календарийн хэвлэлтэнд	13,986,000.00	Гэрээтэй	
4	2006.03.21	231	Их Монгол 800 сан	Сангийн хэрэгцээнд компьютер авахад	1,777,500.00	Албан бичиг	
5	2006.05.16	6	Их Монгол 800 сан	Вэб хуудасны зардал	4,875,565.00	Үндэсний хорооны тогтоолтой	
6	2006.06.20	1	Хэрээжи	Лого бүхий футволка хийлгэхэд	11,750,000.00	Гэрээтэй	
7	2006.06.27	21	Он энд Офф продакшн	Хандивийн тоглолтын зардал	42,897,495.00	СУЗ-ийн тогтоолтой	
8			Интерпресс ХХК	Ширээний календарийн хэвлэлтэнд	1,407,200.00	СУЗ-ийн тогтоолтой	
9	2006.08.05		Их Монгол 800 сан	Чуулга уулзалтын зардал	1,841,050.00	СУЗ-ийн орлогч дарга баталсан	
10			Их Монгол 800 сан	Үндэсний хороо, сангийн хаалтын ажиллагаа, хэвлэлээр мэдээлэх болон шагнал урамшилд	15,766,348.00	СУЗ-ийн тогтоолтой	
					105,624,491.00		
					133,164,717.77		
Сангийн үйл ажиллагаа, хандивын хөрөнгө босгох арга хэмжээний дүн							
Санхүүжилт хэлбэрээр зарцуулсан нь:							
Урлаг уран бүтээл туурвихад							
1	2006.07.19	161	Д.Машлай	Чингис хаан дууны найруулгад	350,000.00	Үндэсний хорооны албан бичигтэй	үгүй
2	2006.07.20	22	Дархан-Уул аймгийн Залуучууд театр	"Их хааны хатад" дуурь	20,000,000.00	СУЗ-ийн тогтоолтой	Тийм
3	2006.07.20	22	Монголын хөгжмийн зохиолчдын холбоо	"Өүлэн-Эх" дуурь	5,800,000.00	СУЗ-ийн тогтоолтой	Тийм
4	2006.10.19	26	"Хүрэл тулга" холбоо	Монгол-Японы хамтарсан "Чингис хаан" кино	255,500,000.00	СУЗ-ийн тогтоолтой	Тийм
5	2006.10.19	23	"Чингис хаан кино" сан	Монголын уран бүтээлчдийн "Чингис хаан" кино	480,000,000.00	СУЗ-ийн тогтоолтой	Тийм
6	2006.10.19	25	Монголын урчуудын эвлэлийн холбоо	МУ-н үндсэн хууль бүтээх ажилд	50,000,000.00	СУЗ-ийн тогтоолтой	Тийм
7	2007.02.26	33	Баян-Өлгий аймаг	Их хааны хатад дуурь бүтээхэд хэтэрсэн зардал	4,500,000.00	СУЗ-ийн тогтоолтой	Тийм

8	2007.02.26	33	УИХ-ын гишүүн Д.Арвин, Ардын уран зохиолч Ш.Сүрэнжав, МУГЖ А.Энхтайван	Цагаан дарь эх буюу эзэнт төрийн хатан уран сайхны кино	40,000,000.00	СУЗ-ийн тогтоолтой	үгүй
9			Эшгиглэн ХХК	Япон улсад бэлэглэх 80 ширхэг морин хуурын үнэ	8,000,000.00		үгүй
	Дүн			Ном, CD хэвлэх болон шагнал урамшилд	864,150,000.00		
10	2007.02.15	29	Зохиолч, яруу найрагч Ш.Гүрбазар	"Монголын их үнэмшил", "Би Монголоороо гоёдог" CD	6,000,000.00	СУЗ-ийн тогтоолтой	үгүй
11	2007.02.15	31	Ардын уран зохиолч Т.Галсан	Монгол жангарын боть	10,000,000.00	СУЗ-ийн тогтоолтой	үгүй
12	2007.02.15	27	Кино найруулагч Г.Жигжидсүрэн	Монгол кино ном	6,000,000.00	СУЗ-ийн тогтоолтой	үгүй
13	2007.02.26	33	Шинжлэх ухааны түүхийн хүрээлэн	Түүхийн сурвалжийн 11 ном хэвлүүлэх	30,000,000.00	СУЗ-ийн тогтоолтой	үгүй
14	2007.02.26	33	Үндэсний хорооны ажлын алба мэдээлэл сурталчилгааны ажлын хэсэг	Их ойн хүрээнд бүтээгдсэн 6 ширхэг кино хувилах	15,000,000.00	СУЗ-ийн тогтоолтой	үгүй
15	2007.02.26	33	Үндэсний хорооны ажлын алба мэдээлэл сурталчилгааны ажлын хэсэг	"Их Монгол-800" ойн үйл ажиллагааны тайлан ном	15,000,000.00	СУЗ-ийн тогтоолтой	үгүй
16	2007.02.26	33	Эмэгтэйчүүдийн байгууллага	Монголын эмэгтэйчүүд А-Я гэсэн ном хэвлүүлэхэд шаардагдах зардал	8,700,000.00	СУЗ-ийн тогтоолтой	үгүй
17	2007.02.26	33	Монгол улсын гавьяат багш Д.Банди	Хүннүгээс эхлээд Монголын хаадын зураг тайлбарын цомог зохиогчийн шагналд	1,400,000.00	СУЗ-ийн тогтоолтой	үгүй
	Дүн			Хөрөнгө оруулалт буюу бүтээн байгуулалтад	92,100,000.00		
18	2007.02.15	30	Соёлын төв өргөө	Концертийн танхимын шинэчлэлд	281,000,000.00	СУЗ-ийн тогтоолтой	үгүй
19	2007.02.26	33	УИХ-ын гишүүн Б.Бат-Эрдэнэ, ШУА-ын Археологийн хүрээлэн	Хэрлэнгийн хөдөө арал дахь Археологийн судалгааны төв, музейн барилгын тохижилтын зардалд	18,800,000.00	СУЗ-ийн тогтоолтой	үгүй
20	2007.02.26	33	ШУА-ын Түүхийн хүрээлэн	Архангай аймгийн Цэцэрлэг сум Сайрхээрийн талд босгосон гэрэлт хөшөөний материалын үнэд	1,500,000.00	СУЗ-ийн тогтоолтой	үгүй
21	2007.02.26	33	ТЗУААЭГазарт	Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө	54,300,000.00	СУЗ-ийн тогтоолтой	үгүй
	Дүн				355,600,000.00	СУЗ-ийн тогтоолтой	

Бусад үйл ажиллагааны санхүүжилтэд						
		Монголын оюутны холбоо	МОХ-ноос зохион байгуулсан Сэлбэ голыг цэвэрлэхэд	500,000.00	Су.Батболд дарга цохолт хийсэн	үгүй
22	2006.07.20	Баяр наадмын комисс	Хүй долоон худагт урлаг, соёлын арга хэмжээ зохион байгуулахад	5,000,000.00	СУЗ-ийн тогтоолтой	үгүй
24	2007.02.26	Интерпресс ХХК	Тэмүүжинг хэн сайн мэдэх вэ аян	10,000,000.00	СУЗ-ийн тогтоолтой	үгүй
25	2007.02.26	Барилга хот байгуулалтын яам	Их хуралдайн Шар ордны макет хийлгэсэн зардал	5,600,000.00	СУЗ-ийн тогтоолтой	үгүй
26	2007.02.26	Хөвсгөл аймгийн Чандмань өндөр сум Засаг дарга Х.Энхтүвшин	Алунгоо эхийн сургаалийн баярт дутагдсан хөрөнгө	1,233,000.00	СУЗ-ийн тогтоолтой	Тийм
27	2007.02.26	ШУА-ын Түүхийн хүрээлэн	Богд хаант Монгол улс байгуулагдсаны 100 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний бага хурлын зардал	2,200,000.00	СУЗ-ийн тогтоолтой	үгүй
	2007.02.26	Цахим өртөө ТББ	Гадаадад суугаа монголчуудын нэгдсэн мэдээллийн сан бий болгох	29,000,000.00		
	Дүн			53,533,000.00		
		Санхүүжилт хэлбэрээр олгосон дүн			1,365,383,000.00	
	Нийт дүн			1,498,547,717.77		
		Үүнээс: нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнд зарцуулагдсан дүн, эзлэх хувь			817,033,000.00	59.8
		төлөвлөгөөнд огт тусгагдаагүй арга хэмжээний дүн, эзлэх хувийн жин			548,350,000.00	40.2

Хавсралт 4

Үндэсний татварын ерөнхий газраар шалгуулах байгууллагын жагсаалт

Д/д	Шийдвэр		Байгууллага	Зардлын товч утга	Дүн	Тайлбар		Үндэсний хорооны төлөвлөгөөнд тусгагдсан эсэх
	Огноо	Дугаар						
1	2006.10.19	26	"Хүрэл тулга" холбоо	Монгол-Японы хамтарсан "Чингис хаан" кино	255,500,000.00	СУЗ-ийн тогтоолтой	Тийм	
2	2006.10.19	23	"Чингис хаан кино" сан	Монголын уран бүтээлчдийн "Чингис хаан" кино	480,000,000.00	СУЗ-ийн тогтоолтой	Тийм	
3	2007.02.26	33	УИХ-ын гишүүн Д.Арвин, Ардын уран зохиолч Ш.Сүрэнжав, МУГЖ А.Энхтайван	Цагаан дарь эх буюу эзэнт төрийн хатан уран сайхны кино	40,000,000.00	СУЗ-ийн тогтоолтой		үгүй
			Дүн		775,500,000.00			
				Ном, CD хэвлэх болон шагнал урамшилд				
10	2007.02.15	29	Зохиолч, яруу найрагч Ш.Гурбазар	"Монголын их үнэмшил", "Би Монголоороо гоёдог" CD	6,000,000.00	СУЗ-ийн тогтоолтой		үгүй
11	2007.02.15	31	Ардын уран зохиолч Т.Галсан	Монгол жангарын боть	10,000,000.00	СУЗ-ийн тогтоолтой		үгүй
12	2007.02.15	27	Кино найруулагч Г.Жигжидсүрэн	Монгол кино ном	6,000,000.00	СУЗ-ийн тогтоолтой		үгүй
13	2007.02.26	33	Шинжлэх ухааны түүхийн хүрээлэн	Түүхийн сурвалжийн 11 ном хэвлүүлэх	30,000,000.00	СУЗ-ийн тогтоолтой		үгүй
14	2007.02.26	33	Эмэгтэйчүүдийн байгууллага	Монголын эмэгтэйчүүд А-Я гэсэн ном хэвлүүлэхэд шаардагдах зардал	8,700,000.00	СУЗ-ийн тогтоолтой		үгүй
15	2006.06.20	1		Лого бүхий футволика хийлгэхэд	11,750,000.00	Гэрээтэй		
			Хэрээжи	Их Монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойн арга хэмжээг сурталчлах	80,000,000.00	УХ-ны ажлын албанаас олгосон санхүүжилт		
			Чингис хаан холбоо ТББ	Чингис хаан цахим сан бүтээх	14,700,000.00	УХ-ны ажлын албанаас олгосон санхүүжилт	Тийм	
			Дүн		167,150,000.00			
			Нийт дүн		942,650,000.00			



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2007 оны 12 сарын 20 өдөр

Дугаар 94

Улаанбаатар хот

Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13.4.5, “Гүйцэтгэлийн шалгалтын журам”-ын 23.2, “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

Нэг.Их Монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх Үндэсний хорооны төсвийн хөрөнгийн зарцуулалтад хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.

Хоёр.Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

Гурав.Аудитын тайланг УИХ-ын Төсвийн Байнгын хороо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Н.Энхболд, Төр, засгийн үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын дарга Ж.Бадраа нарт хүргүүлсүгэй.

Дөрөв.Аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2008 оны 3 дугаар сарын 20-ны дотор Үндэсний аудитын газарт танилцуулахыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төр, засгийн үйлчилгээ аж ахуйг эрхлэх газрын дарга нарт зөвлөсүгэй.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Л.ЖАВЗМАА

Ерөнхий аудиторын 2007 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 97 дугаар тушаалын хавсралт

Төлбөр, зөрчлийн жагсаалт

УХАО-127 /мянган төгрөг/

№	Төлбөрийн товч утга	дүн	Төлбөр зөрчлийг хариуцах	
			албан тушаал	нэр
1	Хүн амын орлогын албан татварыг төсөвт төвлөрүүлэх	193.4	МУАХолбооны захирал	Б.Тунгалаг
			ерөнхий нягтлан бодогч	Г.Бажиг
2	Хүн амын орлогын албан татварыг төсөвт төвлөрүүлэх	1614.2	МУЭХорооны орлогч дарга	П.Цэгмэд
			ерөнхий нягтлан бодогч	Ө.Ганчимэг
3	Төсвийн хөрөнгийг зориулалт бус зүйлд зарцуулсан	380.0	МУИС-ын МСТөвийн зөвлөх профессор	Дашцэдэн
4	Төсвийн хөрөнгийг зориулалт бус зүйлд зарцуулсан	780.0	МОНЦАМЭ агентлагийн захирал	Д.Ариунболд
			ерөнхий нягтлан бодогч	Л.Цэвэгжав
5	Төсвийн хөрөнгийг зориулалт бус зүйлд зарцуулсан	640.7	Үндэсний хорооны ажлын албаны ерөнхий зохицуулагч	Д.Гарам-Очир
			ерөнхий нягтлан бодогч	П.Буяндүүрэн
			Мэдээлэл сурталчилгааны ажлын хэсгийн нарийн бичиг	Д.Нагаанбуу
6	Хөрөнгийг нөхөн төлүүлэх	2,999.5	Мэдээлэл сурталчилгааны ажлын хэсгийн нарийн бичиг	Д.Нагаанбуу
7	Харилцах дансны үлдэгдлийг төсөвт төвлөрүүлэх	15,780.0	Их Монгол-800 сангийн захирал	Н.Энхжаргал
			ерөнхий нягтлан бодогч	Н.Дэлгэрмаа
	Төлбөрийн дүн	22,387.8		
	Зөрчил			
1	Данс бүртгэлд тусгуулах	2,635.0	Уран зургийн галарейн захирал	Д.Энхцэцэг
			ерөнхий нягтлан бодогч	Ц.Эрдэнэсүвд
1	Данс бүртгэлд тусгуулах	4,202.0	МОНЦАМЭ агентлагийн захирал	Ариунболд
			ерөнхий нягтлан бодогч	Цэвэгжав
	Зөрчлийн дүн	6,837.0		
	Нийт төлбөр, зөрчлийн дүн	29,224.8		